

ДЭЛХИЙ ХӨТӨЧ

Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн
“The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна.
Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох.
ЗОВЛОН ЗҮДГҮҮР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

Энэ удаагийн дугаарт Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. Тус сэтгүүлд дэвшүүлэн тавьсан таамаг төлөвийн 90 хувь нь биелдгээрээ давуу талтай гэдгийг үг сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэсэн. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг. Бид Монголын уншигчдыг ч энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

Үнэ: 40.000₮

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999 4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ,
ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800 6228/

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Бариянжав /9409 2904/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:
Б.Үүрийнтуяа
Б.Энхцэцэг
Г.Орхон
Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:
Б.Энхмөнх


ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
I хороо, Экспресс тауэр. 1101 тоот
Вэб: www.mongolianeconomy.mn
И-мэйл: info@mongolianeconomy.mn
Утас: 976-7011 5476


15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762

Борлуулах цэгүүд:

“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетийн бүх салбар
“Макс” супермаркетийн бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн:
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр
“Max mall” дахь салбарууд

 [facebook.com/
Mongolian.Economy](https://facebook.com/Mongolian.Economy)

 [twitter.com/
EconomyMongolia](https://twitter.com/EconomyMongolia)

 [youtube.com/user/
MongolianEconomy](https://youtube.com/user/MongolianEconomy)

Эдийн засаг

6 Өндөр итгэл ба хариуцлага

Ардчилсан сонгууль явагдсанаас хойших Монгол Улсын долоо дахь УИХ-ын дарга, 29 дэх Ерөнхий сайд, ес дэх Улаанбаатар хотын захирагч, долоо дахь НИТХ-ын дарга зэрэг албан тушаалтнаа тодруулж чадлаа.

8 Гадаадын ажиглагчид сонгуулийг ингэж дүгнэв

Хүний нэр төрд халдан гутаах нь эрүүгийн гэмт хэрэг. Харин Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрэн сурвалжилсан нэвтрүүлэг ажиглагдаагүйгээс харахад Монголын сэтгүүлчид бусдын нэр төрд халдахаас айдаггүй гэж үзлээ.

10 ASEM хүрэх зам

ASEM-ийг зохион байгуулснаараа манайд юу өгөх вэ гэсэн асуулт иргэдийн сэтгэлд хургасаар байгаа. Тэгвэл эдгээр хурал чуулганы зохион байгуулах хугацаанд нэлээд өөрчлөлт бий боллоо.

12 Нэг бөмбөрцөг

Эдийн засгийн талаас авч үзвэл дэлхийн ДНБ-ий 57 хувийг /2012 он/ АСЕМ үйлдвэрлэдэг. Хоёр тивийн эдийн засгийн хамаарал, хөрөнгө оруулалт жилээс жилд өргөжсөөр байгаа юм.

14 Бялуу

Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” компанийн 49 хувийг “Монголын зэс корпораци” 400 сая ам.доллаараар худалдан авчээ.

16 Хүндхэн эхлэл, жаргалтай төгсгөл

Тэдний Монгол дахь анхны зогсоол болсон Тэрэлж байгалийн цогцолборт газар Улаанбаатар хотоос 60 километрийн зайд орших бөгөөд уулархаг газар нутаг, олон төрлийн ан амьтнаар баялаг билээ.

18 Английн Цэрэнбат

Цахим өртөөгөөр овоглодог олон залуус өнөөдөр улс орныхоо хөгжлийн төлөө томоохон албадад ажиллаж буйг харахад баяртай байдаг хэмээн Цэрэнбат ярих. Тэр эгэл жирийн монгол хүний төлөөлөл.

21 Монголын залуучуудын улс төрийн оролцооны өнөөгийн байдал

Удирдлагын академийн улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхмийн эрхлэгч, доктор, доктор, дэд профессор С.Зүльфикарийн улс төрийн судалгааг хүргэж байна



Өндөр итгэл ба хариуцлага

Өнгөрсөн дөрвөн жилд Шинэчлэлийн, Шийдлийн хоёр ч Засгийн газрын хөлд хэтэвч нь хоосорч, хүч нь шавхагдсаар байсан ард түмэн МАН-д эцсийн итгэлийн галыг асаах даалгаврыг өглөө. *хуудас 6*



АСЕМ хүрэх зам

Манай улсад сайн дурынхны хөдөлгөөн үүсээд 25 жил болж байгаа бөгөөд АСЕМ-ийн дараа олон улсын арга хэмжээ зохион байгуулах туршлага бүхий анхны сайн дурын томоохон баг бий болж үлдэх нь хамгийн том ололт болж байна, *хуудас 10.*



Бялуу

Өнөөдөр эрх баригч болсон МАН-ын хувьд асуудлыг шийдэгдсэний дараа бус бизнесийн гэрээ хэлцэл хийгдэхээс өмнө УИХ-д танилцуулж заавар зөвлөгөө авах ёстой байсан гэсэн байр сууриа хамгаалж байна, *хуудас 14.*



Хүндхэн эхлэл, жаргалтай төгсгөл

Жуулчдын дийлэнх нь нийт аяллын хамгийн оргил хэсэг бол Говийн цөл байсан гэдэгт санал нийлж байв, *хуудас 14.*



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН
14 ХОНОГ ТУТМЫН АНГЛИ, МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ СЭТГҮҮЛ

Mongolian Economy

www.mongolianeconomy.mn

Утас: 94092904, 88006228, 70115476, 70115477
И-мэйл: info@mongolianeconomy.mn

АЙЛЧЛАЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ энэ сарын 17-18-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийнэ.

Айлчлалын үеэр талууд эдийн засаг, худалдаа, мэдээллийн технологи, эрчим хүч, соёл, боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн хамтын ажиллагааны салбарт хамтран ажиллах талаар болон бүс нутаг, олон улсын харилцан сонирхсон асуудлаар санал солилцно. Мөн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч Пак Гын Хэ нар албан ёсны хэлэлцээ хийж, Ерөнхий сайд, УИХ-ын дарга нартай уулзах аж.



Ерөнхийлөгч Пак Гын Хэ албан ёсны айлчлалын өмнө АСЕМ-ын дээд түвшний 11 дэх удаагийн уулзалтад оролцох юм байна.

Мөн БНСУ-ын Ерөнхий сайд Хван Гё Ан энэ сарын 15-17-нд манай улсад албан ёсны айлчлал хийнэ. Түүний энэ удаагийн айлчлал нь БНСУ-ын Ерөнхий сайд Ли Хан Дон 2001 онд манай улсад айлчилснаас хойш 14 жилийн дараа хийгдэж буй хоёр дахь удаагийн айлчлал болж буй бөгөөд Монгол, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ойн хүрээнд хэрэгжиж байгаагаараа онцлог юм.

ХҮНИЙ ЭРХ

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс манай улсад ЛГБТ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын шалтгааныг тодорхойлох бие даасан шинжээч томилох шийдвэр гаргасан байна. Нийт 23 улсад ийм бие даасан шинжээч томилжээ. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн “НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын хувьд эдгээр улсад бие даасан шинжээч томилсон нь Хүний эрхийн зөвлөлийн үйл ажиллагааг урагш ахиулах, хяналт тавих, ЛГБТ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг дэлхийн хэмжээнд

тайлагнах чухал алхам болно гэж үзэж байна. Эдгээр шинжээчид ЛГБТ хүмүүсийн сургууль, ажлын байр дээрх ялгаварлан гадуурхалт, эрүүл мэндийн хувьд ноцтой хохирол амсах, дээрэлхүүлэх, орон сууц болон бусад чухал үйлчилгээний хүртээмжийг тэдэнд чиглүүлэхийн тулд юу хийх хэрэгтэйг тодорхойлох болно” гэжээ.

Ирэх есдүгээр сард шинжээчийг томилох бөгөөд эдгээр шинжээч нь гурван жилийн хугацаанд бүрэн эрхтэйгээр бие даасан мөрдлөг явуулж улс орон даяарх ижил хүйтнүүдтэй уулзаж, тэдэнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гол нөлөө үзүүлэх юм.

ПАРЛАМЕНТ

УИХ-ын гишүүд энэ сарын 5-нд тангараг өргөж, чуулганы анхдугаар хуралдааныг эхлүүлээ. Дэгийн дагуу хамгийн ахмад настай гишүүн Ч.Улаан даргалав. Эхний асуудал УИХ-ын даргыг сонгох байсан бөгөөд олонх болсон МАН-ын Удирдах Зөвлөлөөс М.Энхболдыг санал болгосон юм.

Саналт хураалтаар МАН-ын дарга Миеэгомбын Энхболд 86.8 хувийн санал авч УИХ-ын даргаар сонгогдлоо.

Тэрбээр тамгаа гардаж авсны дараа парламентад хандан хэлсэн үгэндээ “Бидэнд мэргэжлийн Засгийн газар байгуулж, нэн даруй үйл ажиллагааг нь эхлүүлэх шаардлагатай байна. Улс орноо өнөөгийн хямралт байдлаас гаргахын тулд шинээр бүрэлдэх Засгийн газар богино хугацаанд эдийн засгийг тогтворжуулах тусгай хөтөлбөр боловсруулан УИХ-аар батлуулах шаардлагатай байна” гэжээ.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

“Багануур” ХК 9.8 сая ширхэг хувьцааг Хөрөнгийн биржээр дамжуулан долдугаар сарын 4-нд олон нийтэд арилжлаа. Нэмж гаргаж буй хувьцааны тоо ширхэг тус компанийн нийт хувьцааны 32 хувьтай тэнцэж байгаа юм. Нэгж хувьцааны үнэ 2650 төгрөг аж.

Тус компанийн 5000 орчим жижиг хувьцаа эзэмшигч компанийн нийт

хувьцааны 25 хувийг эзэмшиж байв. Харин үлдсэн 75 хувийг Засгийн газар эзэмшиж байсан юм. Нэмэлт хувьцаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр парк шинэчлэлт хийн, хуучны тоног төхөөрөмжүүдээ шинэчлэхээр төлөвлөжээ. Хамгийн сүүлд 1990-ээд онд Японы тусламжтайгаар хөрөнгө оруулалт хийсэн аж.

ЭРХ ЗҮЙ

Монгол Улс, БНХАУ-тай “Ялтан шилжүүлэх гэрээ” байгуулснаас хойш анх удаа ял эдлэж буй иргэнээ шилжүүлэн авчээ. Тодруулбал, Монгол Улс өнгөрсөн сард БНХАУ-д 2007 онд 15 жилийн хорих ялаар шийтгэгдсэн иргэнээ шилжүүлэн авсан байна.

Манайх өнөөдрийн байдлаар Бүгд Найрамдах Солонгос улс, Бүгд Найрамдах Хятад Ард улс, Канад, Оросын Холбооны улс, Бүгд Найрамдах Польш улс, Бүгд Найрамдах Турк болон Бүгд Найрамдах Куба улс, Бүгд Найрамдах Энэтхэг улс, Хятад Ард улсын Засаг захиргааны онцгой

бүс Хонконг зэрэг есөн улстай ялтан шилжүүлэх гэрээ байгуулаад байна. Гэрээ, хэлэлцээрийг байгуулснаар тухайн улсад ял эдлэж буй иргэнийг хүсэлтээ гаргасан тохиолдолд эх оронд нь шилжүүлэн авч, үргэлжлүүлэн ялыг нь эдлүүлэх нөхцөл бүрдэж байгаа юм. ■

Тойм

Өндөр итгэл ба хариуцлага

И.ОТГОН

Ардчилсан сонгууль явагдсанаас хойших Монгол Улсын долоо дахь УИХ-ын дарга, 29 дэх Ерөнхий сайд, ес дэх Улаанбаатар хотын захирагч, долоо дахь НИТХ-ын дарга зэрэг албан тушаалтнаа тодруулж чадлаа. Одоо Ерөнхий сайд Жаргалтулгын Эрдэнэбат гэдэг дунд хэрийн насны эрд МАН-ын амлалтыг гүйцэлдүүлж, ачааны хүндийг үүрэх их үүрэг ногдож байна. Нийгэмд МАН мэргэжлийн Засгийн газар байгуулж, эдийн засгийг хямралаас гаргана гэсэн өндөр хүлээлт бий. Харин эрх баригчдын хувьд энэ хүлээлтийг судалж, амласан Засгийн газраа байгуулж ажиллах их хариуцлага үүрлээ. Тэд ажилгүйдэл 11,6 хувьд хүрсэн, улсын төсөв бараг нэг их наядын тасалдалтай хүнд цаг үед эх орны хөгжлийг жолоодох гэж байна. Харин мөнгө нүдний гэм болсон үед Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл хотын шинэ удирдлагад 100 сая төгрөгийн үлдэгдэлтэй төсөв хүлээлгэж өгч байгаа нь сайн хэрэг. Өөрөөр улсын авдранд улаан мөнгө байхгүй. Гэхдээ олон улсын тавцанд Монгол Улсын нэр хүндийг гаргах ASEM-ийн арга хэмжээг сайн зохион байгуулж байгаа АН-ын холбогдох хүмүүст талархах учиртай. Сонгуулийн сонин хачинтай, нартай, хуртай, ASEM-тай өдрүүд үргэлжилж байна.

Сонгуультай холбоотой том жижиг нам, том жижиг улстөрчдийн санал луйвардсан тухай гомдол маргааны үүлийг хага зүсэн шинэ Парламентийг яаралтай ажилд нь оруулсан Ц.Элбэгдорж аргагүй л Ерөнхийлөгчийн зангарагатай байлаа. Тэрбээр шинэ Парламент, Засгийн газарт ASEM-ийн өмнө амжуулах ажил байгааг ч анхааруулсан.

Монголчуудын олонх нь дөнгөж саяхан хийсэн хууль тогтоох дээд байгууллагын сонголтондоо сэтгэл өгч байгаа нь нүднээс нь илт. Зөвхөн дотоодод төдийгүй гаадад зах зээлд ч бидний сонголт эерэг мессежийг өгсөн тухай яриа байна. Улмаар нүүр буруулсан гадаадын хөрөнгө оруулалт ч эргэх хандлагатай байна гэсэн сураг чимээ чих дэлсэж байгаа нь яамай. Энэ бол холоос сонсогдох сураг ажиг төдий зүйл биш, биднийг сонгуулиар амьсгалахаас өмнө болон амьсгалах үед, амьсгалсны дараах өдрүүдэд ч ASEM-ийн дагалдах хурлууд болж, одоо тус чуулганы бүр том хурал болох Business Summit, Дээд чуулганы зочид ирж байгаа учраас

сонгуулийн үр дүнгийн талаар гаднынхны хандлага ерөнхийдөө харагдаж байгаа гэсэн үг.

Тухайн орны улс төрийн орчин тогтвортой байх асуудалд хамгийн өндөр ач холбогдол өгдөг гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд ч Монголын парламентад нэг нам олонх суудлыг авсан тухай мэдээг сонсоод хамгийн түрүүнд “Тогтвортой төрийн бодлого хэрэгжих магадлалтай юм байна” гэсэн найдлага тээж байгаа болов уу гэж төсөөлөхөд ч буруудахгүй. Монголчуудын АН-д итгэх итгэлээ МАН-аар сольж, тэгэхдээ бүр тэнгэр газар шиг зөрүүтэй сонголт хийсэн нь үндсэндээ гадаадын хөрөнгө оруулагчдын адил улс төрийн тогтвортой орчинг л хүссэн хэрэг. Харин итгэлийг хөсөрдүүлэхгүйн тулд МАН амласан мэргэжлийн Засгийн газраа байгуулахаас л тоолуурын заалт жирэлзэнэ. ▶



► Мөн өнгөрсөн дөрвөн жилд Шинэчлэлийн, Шийдлийн хоёр ч Засгийн газрын хөлд хэтэвч нь хоосорч, хүч нь шавхагдсаар байсан ард түмэн МАН-д эцсийн итгэлийн галыг асаах даалгаврыг өглөө. Тус нам Мөрийн хөтөлбөртөө Цалин тэтгэврийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ, Улсын өрийн хэмжээг багасгана, Сургуулийг гурав биш хоёр ээлжээр хичээллэдэг болгоно, Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг хоёр дахин нэмэгдүүлнэ, Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийг тав дахин өсгөнө, Зээлийн хүүг бууруулна, Төмөр замын том төслүүдийг урагшлуулна, Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан бууруулахын зэрэгцээ улсын хэмжээнд ижил үнэтэй болгоно, Гадаадын жуулчдын тоог нэг жилд нэг саяд хүргэнэ гэх мэтээр элгээрээ хэвтсэн эдийн засгийг эдгээх олон сайхан зүйл тусжээ. Мөн Цалинтай оюутан, Цалинтай ээжүүдийг бий болгоно гэсэн нь АН-ын оюутан бүр цалинтай сурах биш онц сурсан нь тэтгэлэг авдаг байх, хуульчлагдсан хүүхэд харах үйлчилгээ зэргээс юугаараа ялгарах, тэдгээрийг дээрдүүлэх санаачилга уу, эсвэл дордуулах уу гэдгийг одоогоор хэлж мэдэхгүй. Тийм болохоор манай сэтгүүлийн хувьд МАН-ын мөрийн хөтөлбөрт нарийн дүн шинжилгээ хийсэн, өмнөх Засгийн газрын алдаа оноо юу байсан, тэгвэл шинэ эрх баригчид юунд анхаарах ёстой вэ гэсэн асуудлуудыг тусгасан анализтай сэтгүүлийг амралт зугаалгын сар дуусч, албаны ажил эхлэхтэй зэрэгцэн бэлтгэн гаргах болно гэдгээ дуулгая.

Харин энэ удаад мэргэжлийн Засгийн газар ямар байх талаар сонирхлоо.

Хэд хоногийн өмнө сошиал ертөнцөд Бат инженер “Мэргэжлийн Засгийн газар” нийтлэл бичиж анх энэ талаар хүмүүст боломжийн ойлголт өгөв. Тэрбээр мэргэжлийн Засгийн газрыг дараах шинжүүдээр тодорхойлж болно хэмээжээ.

1. Бүтцэд нь үйл ажиллагаа, чиг үүргийн давхардал байхгүй
2. Ёс зүйн өндөр мэдрэмжтэй
3. Мэргэжлийн онцлогийг ойлгодог салбарын сайдуудтай
4. Хамгийн чухал нь мэргэжлийн албадын томилгоог улс төржихгүй merit based хийдэг
5. Бүх томилгоо нь шилэн буюу ил тод бөгөөд тусгай хүнд зориулан дүрэм зохиодоггүй.

Байгаа шалгуур нь тэгш үйлчилж, олон хүн өрсөлдөх боломж олгодог.

Merit зарчим юунд хэрэгтэй юм бэ? Энд яагаад үүнийг дахин дахин онцлоод байгаа юм гэж асуух хүн гарч магадгүй. Энэ бол мэдлэг, ур чадварын шалгуурын тухай ойлголт билээ гэжээ.

Тэгвэл Удирдлагын академийн хэсэг эрдэмтэн судлаачид энэ талаар ажиллаж мэргэжлийн тодорхойлолт гаргасныгаа Ерөнхий сайдад өгсөн байна. Тэдний боловсруулснаар бол Нэгдүгээрт, чиг үүргийн яамнаас бусад чиглэлд давхар дээлгүй сайд томилох, Хоёрдугаарт, төрийн захиргааны удирдлагаар тодорхой түвшинд мэргэшсэн, мэдлэг, туршлагатай байх, Гуравдугаарт, тухайн хариуцсан салбараараа өргөн хүрээний ойлголттой байх гэсэн байна.

Харин одоо шинэхэн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат нам дотроо хэр нөлөөтэй вэ гэдгээс шалтгаалж мэргэжлийн Засгийн газар байгуулж чадах эсэх нь харагдана. 40 гаруй настай, дөрвөн жилийн өмнөөс УИХ-д орж ирсэн түүнийг хүмүүс Ч.Сайханбилэгийн Засгийн газартай МАН хамтрах үед Сангийн сайд хийж байсан гэдгээр нь танина. Сэлэнгэ аймгийн Засаг дарга байсан тэрбээр богино хугацаанд хэр баргийн аавын хүүгийн хүрээд байдаггүй Ерөнхий сайдын албанд очиж байна гэдэг намдаа нөлөөтэй байгааг нь харуулах. Гэвч засаг бүрдүүлэх дээр өөрийн байр суурин дээрээ баг зогсож чадах нь эргэлзээтэй. Мэдээж том намд би чи, тэрүүний энүүний хүн гэж сайд болгочих санаатай зүтгүүлэх олон хүн бий. Гэхдээ өнгө мөнгийг биш, Мэргэжлийн засгийн газар гэдэг бамбайгаа өмнөө барьж төрийн албаны туршлагыг нь харж, хариуцлагатай цаг үед хань болчих нөхдөө сонгож чадах эсэх нь түүний овсгоо самбаа мэдэх асуудал.

Сонголтондоо монголчуудын сэтгэл өөдрөг байна. Олон зүйл нуршилгүй МАН л нэг эдийн засгийг сэргээнэ гэсэн олон түмний итгэлийг дааж ►

Зөвхөн дотоод төдийгүй гаадад зах зээлд ч бидний сонголт эерэг мессежийг өглөө. Улмаар нүүр буруулсан гадаадын хөрөнгө оруулалт ч сэргэх хандлагатай байна гэсэн чимээ чих дэлсэж байгаа нь яамай.



▶ ажиллана гэдэгт найдъя.

Ямар ч гэсэн сүүлийн жилүүдэд төрд итгэх итгэл алдарсан монголчуудын хувьд 2016 оны зургаа, долдугаар сар эгэл биш цаг хугацаа байлаа.

МАН-ын мөрийн хөтөлбөр сар гаруйнхны дараах хичээлийн шинэ жилд хэрхэн бэлтгэхээс эхлэх учиртай. Хэн ч хүсээгүй хэрнээ ард олны

алаан болдог энэ талбарт шинэчлэлийг хэрхэн хийх нь эрх баригчдын хувьд том оноо авах, алдахын дэнс юм. Хэрвээ амласнаа хэрэгжүүлэхгүй, төрийн эрх мэдлээ буруу зүйлд хэтрүүлэн ашиглах аваас дөрвөн жилийн дараах сонгуулиар нүүр буруулж чаддаг гэдгээ ард түмэн сая сайн ойлгуулсныг МАН-ынхан эрхбиш тунгаан ажиллана биз ээ. ■

Сонгууль 2016

Гадаадын ажиглагчид сонгуулийг ингэж дүгнэв

Монгол Улсын 2016 оны УИХ болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийн үйл ажиллагааг ажигласан Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Ардчилсан институт, хүний эрхийн газрын ажиглагчид урьдчилсан дүгнэлтээ танилцууллаа. Тус мэдээллийг Европын парламентийн төлөөлөгчдийн тэргүүн Лайма Луциа Андрикиене, ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Сонгуулийг ажиглах хорооны тэргүүн Элчин сайд Одри Гловер нарын хүмүүс хийв.

Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага нь Сонгуулийг ажиглах хороог Монгол Улсад энэ оны тавдугаар сарын 20-нд байгуулжээ. Улмаар үндсэн бүрэлдэхүүн болох 14 гишүүнийг нийслэл хотод, урт хугацааны 14 ажиглагчийг орон даяар хуваарилан ажиллуулсан байна. Нийт 33 орны ажиглагч оролцжээ.

Эрх баригч намын амлалт шударга байдлыг гажуудуулсан

Одри Гловер /ЕАБХАБ-ын Сонгуулийг ажиглах хорооны тэргүүн/

-Монгол Улсын 2016 оны сонгуулийн сурталчилгаа өрсөлдөөнтэй болсон бөгөөд сонгууль эмх журамтай болж өндөрлөлөө. Мөн УИХ-ын сонгууль нь их өрсөлдөөнтэй, эвлэлдэн нэгдэх эрхийг хүндэтгэсэн байдалд болов. Гэхдээ Сонгуулийн тухай хуулиндаа тулгаж өөрчлөлт хийсний улмаас Монголын ардчиллын хөгжилд сөрөг үр дагавартай байсныг зөвтгөх аргагүй. Талуудыг оролцуулсан хэлэлцүүлгийн үндсэн дээр Сонгуулийн тухай шинэ хуулийг 2015 оны арванхоёрдугаар сарын 25-нд сонгуулийн тухай хэд хэдэн хуулийг нэгтгэн баталсан бөгөөд энэ нь сонгуулийн нэгдсэн хууль эрх зүйн хүрээг бий болгоход чиглэсэн нэг дэвшил болсон. Гэвч энэ оны тавдугаар сард УИХ сонгуулийн

холимог тогтолцоог дан олонхийн буюу мажоритар тогтолцоо болгон өөрчилж, нэг мандат бүхий 76 сонгуулийн тойргийг байгуулсан бөгөөд тойргуудын нутаг дэвсгэрийг батлах үйл явц нь ил тод биш, олон нийтийн хэлэлцүүлэг дутмаг тогтоосон шалгуурыг дагаж мөрдсөнгүй. Ингэснээр тойргуудын дунд хүн амын тоо нэлээд зөрүүтэй болсон бөгөөд энэ нь 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагений баримт бичгийн 7.3 дахь хэсэгт заасан иргэн бүр сонгуулийн тэгш эрхтэй байх зарчим болон бусад олон улсын үүрэг, амлалт, стандартуудтай нийцэхгүй байна.

УИХ-ын сонгуулийг СЕХ тэргүүтэй дөрвөн шатлал бүхий сонгуулийн байгууллага удирдан явуулсан. СЕХ санал авах өдөрт бэлтгэнгээ хуульд заасан чухал хугацаануудыг мөрдөн, үүргээ биелүүлэн ажилласан. Гэхдээ тус хорооноос оролцогч талуудтай харилцах ил тод, хариуцлагатай байдал дутмаг байсан нь сонгуулийн үйл явцын найдвартай байдалд итгэх итгэлийг бууруулж байна. Санал тоолох төхөөрөмжийг шалган баталгаажуулах ажлыг СЕХ-ноос оролцогч талуудыг байлцуулан мэргэжлийн хэмжээнд хийлээ. Төхөөрөмжийн үнэн зөв ажиллаж байгаад санаа зовж буй асуудалд хариулт өгөх үүднээс Сонгуулийн тухай хуулиар хэсгийн хороодын 50 хүртэл хувь дээр гараар тоолох тухай заалтыг оруулсан. Гэвч гараар тоолох ажиллагааг явуулах журмыг санал авах өдрөөс хоёрхон хоногийн өмнө эцэслэн гаргасан нь доод шатны хороодод холбогдох сургалтыг зохион байгуулах цаг хугацааг олгосонгүй.

Сонгуульд нийт нэг сая 910 мянга 878 сонгогч оролцохоор бүртгэгдсэн байв. Оролцогч талууд сонгогчдын бүртгэлийн үнэн зөв байдал, бүх сонгогчдыг хамруулсан зэрэгт ерөнхийдөө итгэлтэй байгаагаа илэрхийлж байлаа. Гэвч шүүхээс эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон, мөн үйлдсэн гэмт хэргээс үл хамааран хорих ял эдэлж буй иргэд санал өгөх эрхгүй байна. Хэдийгээр сонгуулийн ▶

▶ бэлтгэл ажил аль хэдийнэ эхлээд байсан ч тавдугаар сард оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу УИХ-ын сонгуульд гадаадад суугаа иргэдээс санал авахыг хүчингүй болгож, гадаадад амьдарч буй Монгол Улсын 150 мянга орчим иргэний сонгуульд оролцох эрхийг хасав.

Гэвч ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн амлалтууд, бусад олон улсын үүрэг хариуцлагатай зөрчилдөж, Сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчийн эрхийг хязгаарласан нэмэлт нөхцлүүдийг зааж өгсөн бөгөөд албан татварын хугацаа хэтэрсэн өр болон зээлийн өртэй, заавал хаах цэргийн хугацаат алба хаагаагүй, түүнчлэн үйлдсэн гэмт хэргээс үл хамааран ял шийтгүүлж байсан бүртгэлтэй иргэдийг хассан байна.

Сонгуулийн сурталчилгаа хэтэрхий хязгаарлалттай байсан ч эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хүндэтгэн сахиж, нэр дэвшигчид өөрсдийн үзэл бодлыг сонгогчиддоо хүргэж чадсан. Эрх баригч намын зүгээс хийсэн томоохон хэмжээний амлалтууд нь сонгуулийн сурталчилгааны шударга байдлыг гажуудуулж байв.

Монголын сэтгүүлчид бусдын нэр төрд халдахаас айдаггүй

Лайма Луцна /Европын парламентийн төлөөлөгчдийн ахлагч/

Аливаа сонгуулийн үйл явц, мөн чанар хоёрыг ялгаж ойлгох нь чухал. Үйл явц бол сонгуулийн зохион байгуулалттай холбогддог. Энэ бол чухал. Гэхдээ сонгуулийн өдөр сайхан байсан гэдэг сайн сонгууль болсон гэсэн үг биш юм. Бидний хувьд мөн чанар илүү чухал. Утга учиртай сонгууль хийхийн тулд сонгогчдод жинхэнэ сонголтыг өгсөн байх ёстой. Энэ удаа сонгогчдод энэ боломж хангагдсан.

Харин сонгуулийн сурталчилгаанд тавьсан зарим хязгаарлалтууд, хэвлэл мэдээлэл зарим талаар улс төрийн ашиг сонирхолд үйлчилсний улмаас сонгогчдод хүрэх бодит бөгөөд тодорхой мэдээллийг хязгаарлалаа. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгуулийн мэдээ мэдээллийг өргөн хүрээтэй нэвтрүүлсэн ч зуучлагчийн үүргээ орхигдуулж, гол төлөв улстөрчдөд шууд нэвтрэх

боломжийг олгож байв. Улс төрийн сурталчилгааны төлбөртэй болон төлбөргүй нэвтрүүлгүүд нь редакцийн хараат бус агуулгыг сүүдэргүүлэхийн зэрэгцээ улс төрийн намуудаас бэлтгэсэн сурталчилгааны материал мэдээний нэвтрүүлэгт багтаж байсан нь хэвлэл мэдээлэлд итгэх итгэлийг алдагдуулж байв. Тиймээс сонгогчдод бие даасан бөгөөд дүн шинжилгээ хийх мэдээ сурвалжлага хомс олдож байлаа.

Мониторинг хийсэн ихэнх телевизийн сувгууд улс төрийн намуудаас бэлтгэж өгсөн эсвэл төлбөртэй сонгуулийн сурталчилгааны материал нэвтрүүлсэн. Энэ нь мэдээ болон улс төрийн сурталчилгааны зааг ялгааг бүдгэрүүлж байна. Хувийн радио телевизүүд зарим нь нэг талыг баримталсан ба дийлэнх хэсгийг төлбөртэй улс төрийн сурталчилгаа эзэлж байв. Тухайлбал, “Ийгл” телевизийн хувьд мэдээний нэвтрүүлгийн 26 хувиар тус бүр АН, МАН-ыг сайшааж, “ТВ 5” телевиз 44 хувиар МАН-ыг сайшаасан бол “ТВ9” телевиз МАХН-ыг 28 хувиар сайшаажээ. Эдгээр гурван телевизийн сувгийн мэдээний нэвтрүүлгийн өнгө аяс нь хоёр том намд илүү эерэг хандсан байдалтай байсан.

Хүний нэр төрд халдан гутаах нь эрүүгийн гэмт хэрэг. Харин Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрэн сурвалжилсан нэвтрүүлэг ажиглагдаагүйгээс харахад Монголын сэтгүүлчид бусдын нэр төрд халдахаас айдаггүй гэж үзлээ.



Цаашид сонгогчдын боловсрол, хараат бус хэвлэл мэдээлэл зэрэгт анхаарвал зохих асуудал байна гэж үзлээ. Эцэст нь дүгнэхэд сонгууль орон даяар эмх журамтай явагдаж өнгөрлөө. Хэдийгээр саналын нууцлал тэр бүр хангагдахгүй байсан ч ерөнхийдөө санал хураалтыг эерэг гэж үнэлсэн болно. ■


Цаг үе

ASEM хүрэх зам

Ц.БУНИА

“Ази Европын парламентын түншлэлийн IX уулзалт”-аас хойш олон нийт ASEM гэж юу болох, хэн хаанаас ирж оролцож ямар асуудлыг хэрхэн хэлэлцдэг тухай илүү нарийн ойлгох болсон. Анхны чуулганаас 44 заалт бүхий есөн хуудас тунхаг бичиг гарсан ч Улаанбаатарын гудамжаар алхаж яваа Доржийн хувьд онцын сонирхол татаагүй байж мэдэх юм. Магадгүй түүнд олон улсын худалдаа, бүс нутгийн интеграци, дэлхийн уур амьсгалын өөрчлөлт зэрэг сэдвүүдээс илүү хоёр сарын дараа болох сонгууль, эсхүл наадмын амралт чухал байсан. Гэвч эдгээр өдрүүд бол нийт монголчуудын хувьд Азийн, цаашлаад дэлхийн иргэн гэдгээ хүчтэй мэдэрсэн цаг үе тохиож байна. Дорж ч мөн ASEM-ийн зочдыг угтах шинэхэн зассан тохилог гудамжаар алхаж, ASEM-ийн уур амьсгалыг нүдээр үзэж, гараар хүрч буй.

ASEM-ийн Дээд хэмжээний уулзалтын өмнө түүний хүрээнд дагалдах есөн хурал зохион байгуулагдлаа. Хамгийн түрүүнд Парламентчид дөрөвдүгээр сарын 21-23-нд Улаанбаатар хотноо чуулсан. Энэ үеэр ASEM-ийн гишүүн 32 орны болон Европын парламентын нийт 170 гаруй төлөөлөгч оролцож, “Үр дүнтэй олон талт харилцаа, хамтын ажиллагаа”, “Ирээдүйн төлөөх түншлэл” сэдвээр санал бодлоо солилцсон. Уг хурлыг Монгол Улсын Их хурлын дарга З.Энхболд удирдан явуулсан юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж нээлтийн үгэндээ ASEM-ийн уулзалтуудаар 100 гаруй сэдэв хөндөгдөж, удирдагчид төдийгүй нийгмийн бүх төлөөлөл оролцдог ихээхэн онцлогтой арга хэмжээ болохыг тэмдэглэсэн юм. Түүнээс хойш тавдугаар сарын 12-13-нд “ASEM-ийн Ахлах албан тушаалтнуудын уулзалт”, зургадугаар сарын 09-10-нд “Сангийн сайд нарын 12 дугаар уулзалт”, зургадугаар сарын 20-21-нд “Ази-



Дээд хэмжээний чуулганд 34 орны Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын түвшний төлөөлөгч оролцоно. Мөн БНСУ-ын Ерөнхийлөгч, Сингапурын Ерөнхий сайдын албан айлчлал болно.

Европын хүнсний аюулгүй байдлын зөвлөлдөх уулзалт” болж тэдгээр сэдвийн нэлээдийг хэлэлцээд байна.

Тухайлбал, Ази-Европын хүнсний аюулгүй байдлын зөвлөлдөх уулзалтаар бүс нутгийн хүнсний хангамж, хүнсний бүтээгдэхүүний худалдаа, тээвэр, логистик, уур амьсгалын өөрчлөлт хүнсний аюулгүй байдал зэргээс гадна органик хүнсний үйлдвэрлэл, баталгаажуулалт, зах зээлийн чиг хандлага, генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, цаашдын чиг хандлага, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хорио цээр, хил дамнанас малын халдварт өвчний

асуудал зэрэг чухал сэдвүүдийг хэлэлцсэн нь Доржийн амьдралаас хол хөндий асуудал огтхон ч биш юм. Эдгээр дагалдах хуралдаанаар хэлэлцсэн асуудлуудыг нэгтгэн зөвлөмж гаргаж Дээд хэмжээний уулзалтад оролцогч бодлогыг хэрэгжүүлэх түвшний эрхмүүдэд сонордуулдаг. Дэлхий улам даяаршин “хавтгайрч” байгаа энэ үед ASEM-ийн уулзалтын оролцогчид асуудлууд дээр нэгдсэн байр суурьт хүрэх нь эргээд Дорж шиг Ази-Европын дөрвөн тэрбум гаруй ард түмний амьдрал ахуйд шууд нөлөөтэй билээ.

Ахлах албан тушаалтнуудын ▶



Фотог Б.Бямба-Очир

► уулзалтын үеэр Ази, Европын орнуудын төр, засаг төдийгүй ард иргэд хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх асуудлыг чухалчилж хэлэлцсэн. Нэг эх газарт орших хоёр тивийн иргэдийн аялал жуулчлал, худалдаа, шуудан харилцаа өргөжихийн хэрээр бүс нутгуудын эдийн засаг тогтвортой өсч, улс орны хөгжлийн зааг ялгаа арилж, хувь иргэний орлого нэмэгдэнэ. Сангийн сайд нарын 12 дугаар уулзалтаар “Ази-Европын хөгжлийн төлөөх түншлэл” сэдвийн хүрээнд Ази-Европын хамтын ажиллагааг өргөжүүлэх, илүү хүргэмжтэй тэнцвэртэй өсөлтийг бий болгож хоёр тив хамтдаа хөгжил

цэцэглэлтэд хүрэх талаар идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлсэн. Үүний тулд бүс нутаг дамнасан дэд бүтцийн төслүүдийг дэмжин хэрэгжүүлэх нь чухал гэлцсэн юм. ОУВС-гийн удирдах захирлын орлогч Мицүхиро Фүрусава Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нь зайлшгүй байгааг, мөн илүү нягт харилцан хамтрах нэгдмэл саналд хүрч дэлхийн, бүсийн болон хоёр талын харилцаагаа шинэчлэх хэрэгтэй байгааг онцолсон бол Европын Холбооны комиссын дэд ерөнхийлөгч Валдис Домбровскис хөгжингүй орнуудын сэргэлт нь Азийн эдийн засгаас ихээхэн хамаарч байгааг хэлээд “Европын хувьд Азийн эдийн засгуудад дараагийн үед орох шилжилтэд туслах бодлого, эдийн засгийн туршлага байгаа” гэсэн юм.

ASEM энэ өдрүүдэд Залуучуудын чуулган редакторуудын хуралдаанаар үргэлжилж байна.

Монголд юу үлдэх вэ?

ASEM-ийг зохион байгуулснаараа манайд юу өгөх вэ гэсэн асуулт иргэдийн сэтгэлд хургасаар байгаа. Тэгвэл эдгээр хурал чуулганы зохион байгуулах хугацаанд нэлээд өөрчлөлт бий боллоо. Улаанбаатар хотын 13 гудамж, талбайд засвар, тохижилтын ажил хийсэн. ИНЕГ өөрсдийн төсвийн хөрөнгөөр 21.7 тэрбум төгрөг санхүүжилт хийн “Чингис хаан” олон улсын нисэх буудлын агаарын хөлгийн есөн зогсоол шинээр барьж, хөөрч буух зурвасын цемент бетон хучилтыг хүчитгэн, нисэх буудлыг тохижуулсан. Ингэснээр нийт 34 агаарын хөлгийг байршуулах хүчин чадалтай болсон төдийгүй транзит заалыг шинээр ашиглалтад оруулжээ.

ASEM-ийн Дээд түвшний уулзалтад оролцох төр, засгийн тэргүүн нарын байрлах “ASEM Вилла” хотхоныг ашиглалтад оруулсан гэх зэрэг ASEM-ийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалт их. Зөвхөн дэд бүтэц төдийгүй мэргэжилтэн, боловсон хүчнүүдэд оюуны хөрөнгө оруулалт мөн хийж байна. Тухайлбал, ASEM-ийн дээд түвшний уулзалт болон түүний дагалдах хурлуудын зохион байгуулалтад сайн дураар ажиллахаар бүртгүүлсэн 1500 орчим оюутан, залуусыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан. Сургалтаар дипломат ёс, дэг жаяг, төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээний үеэр баримтлах зарчим, сайн дурын ажилтны ажлын

байранд тавигдах шаардлага, хөтөч тайлбарлагчаар болон үйлчилгээний салбарт ажиллах стандарт шаардлага гэх мэт мэдлэгийг олгожээ. Манай улсад сайн дурынхны хөдөлгөөн үүсээд 25 жил болж байгаа бөгөөд ASEM-ийн дараа олон улсын арга хэмжээ зохион байгуулах туршлага бүхий анхны сайн дурын томоохон баг бий болж үлдэх нь хамгийн том ололт болж байна. Түүнчлэн албан ёсны төлөөлөгчид байрлах 40 гаруй түнш зочид буудал бэлтгэлээ хангаж, үйл ажиллагаандаа шинэ стандарт, үйлчилгээг нэвтрүүлээд байна. Тэдгээр зочид буудлын нийт 150 гаруй менежер мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, олон улсын хурал зохион байгуулах аргазүй, өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгчдөд үйлчлэх зохион байгуулалтад суралцаж, мэдлэг туршлагаа нэмэгдүүлсэн байна. Сургалтыг БНСУ-ын зочлох үйлчилгээний мэргэшсэн багш нар удирдан явуулжээ.

Зөвхөн энэ сарын 15-16-нд зохиогдох ASEM-ын дээд хэмжээний уулзалтад нийт 5000 гаруй зочин, төлөөлөгч оролцох төлөвтэй байгаа. Энэ нь Монгол дахь MICE жуулчлалын эхлэл болно гэж албаныхан учирлаж буй. Энэ бүх ажлыг амжилттай зохион байгуулснаар Монгол Улсад нэр хүнд үлдэх бөгөөд дараа дараагийн олон улсын томоохон хурал чуулганыг зохион байгуулах боломж нээгдэж, түүний хэрээр алба, ажлын шугамаар Монголд жуулчлагчдын тоо нэмэгдэнэ. Зохион байгуулалтын хувьд эхнээсээ л магтаал ирж байгаа. ASEM-ийн 10 дугаар уулзалтыг амжилттай зохион байгуулсан БНИУ-ын Сенатийн Ерөнхийлөгч эрхэмсэг ноён Пиетро Грассо “Ази Европын парламентын түншлэлийн IX уулзалт”-д оролцох үеэрээ амжилттай, хариуцлагатай зохион байгуулж байгаа Монгол Улсад баяр хүргээд, “Пакс Монголика буюу Их Монгол Улсын үед тогтоосон тогтвортой худалдаа, соёлын солилцооны эрин үе Улаанбаатар хотоос эхэллээ” гэсэн юм.

Харин Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж цаашдаа газар нутгийн байршлынхаа давуу талыг ашиглаад Улаанбаатар хотод “ASEM Center” байгуулан, дараа дараагийн хурлуудыг зохион байгуулах улс орнуудад мэдээллийн дэмжлэг үзүүлдэг байх санаачилга гаргаад байгаа. Тиймээс тэр нэр төр Монгол Улсад хэрэгтэй. Монголын иргэн Доржид ч хэрэгтэй. ■

Хамтын ажиллагаа

Нэг бөмбөрцөг

Ц.ЭЛБЭГСАЙХАН

Уралын нуруугаар зааглагдах хоёр тив бусад шиг далай тэнгисээр алслагдаагүй. Бүхэлдээ нэг тектоник хавтан дээр оршиж буй хоёр тивийн хүн ард торгоны зам, цайны зам гэхчлэн худалдаа арилжааны түүхэн холбоотой. ХХ зууны хоёр дахь хагасаас хойш илүү албан ёсны, ажил хэрэгч хамтын ажиллагаа тогтоож, харилцааныхаа үнэ цэнийг нэмэгдүүлж буй. Энэ хүрээнд АСЕАН, АSEM, АСЕФ зэрэг байгууллага тогтмол, идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа. АSEM бол хамгийн өргөн хүрээг хамарч буй нь бөгөөд АСЕАН-ы 10, ЕХ-ны 28 гишүүн орон болон Хятад, Энэтхэг, Япон, Монгол, Пакистан, Өмнөд Солонгос, Норвеги, Швейцарь зэрэг 50 гаруй орон, олон улсын байгуулагыг нэтгэсэн бүс нутгуудын хамтын ажиллагаа, зөвшилцлийн процесс.

Хамтын ажиллагааны гол зарчмаа 2000 онд Сэүл хотноо “Хүний эрх болон хууль дээдлэх ёс, ХХI зууны сайн засаглал” хэмээн тодорхойлсон. Эдгээр улс, байгууллагууд терроризм, даяар асуудал болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтран тэмцэгчид. Өөр бусад дэлхийн асуудлуудыг шийдвэрлэх, эцэслэхэд хоёр тивийн өргөн хүрээний хамтын ажиллагаа нэн чухал байр суурь эзэлнэ. Учир нь дэлхийн хүн амын 63.5 хувийг АSEM-ийн улсууд бүрдүүлж байна.



Хэн хэний гарыг атгаж байна вэ?

Эдийн засгийн талаас авч үзвэл дэлхийн ДНБ-ий 57 хувийг /2012 он/ АSEM үйлдвэрлэдэг. Хоёр тивийн эдийн засгийн хамаарал, хөрөнгө оруулалт жилээс жилд өргөжсөөр байгаа юм. Хөрөнгө оруулалтын урсгалыг харахад эсрэгцсэн чиглэлтэй байгаа нь хамтын ажиллагаанаас хоёул хожиж байгаагийн илэрхийлэл. Гэхдээ ерөнхий хүрээгээр харахад энэ нь үнэн боловч бүс нутаг дахь эдийн засаг тус бүрээр салгаж харвал харилцан адилгүй ажээ. Хоёр тивийн худалдаа нь эдийн засгийн хөгжлөөрөө ойролцоо орнуудын хооронд түлхүү хийгдэж байгаа бөгөөд энэ нь ирээдүйд эдийн засгийн эрс ялгаатай байдлыг бүс нутгуудын аль альд нь бий болгож мэднэ. Тиймээс буурай хөгжилтэй орнуудтай хийх худалдааг

нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа тухай 2010 онд эдийн засагч Beginda Pakpahan “Хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнц дээрх Ази-Европын бүс нутаг дамнасан хамтын ажиллагаа” хэмээх өгүүлэлдээ дурдсан байна. ЕХ-28 болон Норвеги, Швейцари улсад Азиас хийж буй гол хөрөнгө оруулалтыг Хятад, Солонгос, Тайландаас хийдэг бөгөөд сүүлийн жилүүдэд Энэтхэг, Австралийн хөрөнгө оруулалт нэмэгджээ. Евро бүсийн орнуудын Азийн улсуудтай хийсэн худалдааны тэнцлийг авч үзэхэд БНХАУ болон ОХУ-тай хийсэн худалдаа нь бусад АSEM-ын орнуудыг нийлүүлснээс ч их. Тэр дундаа нийт худалдааны 30 гаруй хувийг зөвхөн БНХАУ-тай хийж байгаа юм.

Ази Европын бүс нутаг хоорондын худалдаа хөрөнгө оруулалт арван жилийн турш нэлээд өргөжин тэлсэн. Гэсэн хэдий ч, Европоос Ази руу хийх нийлүүлэлт сүүлийн хэдэн жилд буурч байгаа юм. Энэ нь магад дэлхийн санхүүгийн хямралын дараах нөлөөлөл бөгөөд бодлого, худалдаанд тулгуурласан харилцаанаас үүдэлтэй. Түүнчлэн, цаашид Ази, Европын хооронд худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчлах цогц худалдааны хэлэлцээр нь дутагдаж байгааг өнгөрсөн тавдугаар сарын 2-нд Frankfurt хотноо зохион байгуулсан “Ази-Европын Эдийн засгийн хамтын ажиллагаа: Илүү том худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих нь” сэдэвт АХБ-ны семинарын үеэр хөнджээ.

Чиг хандлага ба Монголын боломж

Ази Европын хооронд олон талт хамтын ажиллагааны үр дүнд эдийн засаг, соёлын хувьд нягт холбогдсон. Даяаршлын эрин үе нь худалдаа, хүний эрх, аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хамт шийдэх шинэ сорилт болон шаардлагыг бий болгосон. Европын холбооны хувьд Азийн дундаж улсууд (Энэтхэг, Хятад, Япон) болон бүсийн байгууллагууд (АSEM, АСЕАН)-тай хэд хэдэн стратегийн түншлэл байгуулж Азийн шинэ эдийн засагт орж ажиллаж байна.

Ази талаас ч Европтой худалдаа харилцаагаа өргөжүүлэх сонирхол туйлын их. Тийм ч учраас БНХАУ-ын “Шинэ торгоны зам”, Монголын “Талын зам”, Европын орнуудыг Япон, Солонгостой хамгийн богиноор холбох “АНЗ” хурдны авто замын ОХУ, Монгол, БНХАУ-ын хамтарсан хөтөлбөр хэрэгжиж байна. Монгол Улсын хувьд Евро бүс болон Азийн томоохон зах зээл Хятад, Япон, Солонгосыг холбох гол цэг болдог газар зүйн байршил нь ихээхэн давуу талыг бий болгож байгаа юм.

БНХАУ-ын дарга Си Жиньпин Шинэ торгоны зам буюу “Нэг бүс, нэг зам” санаачилгыг 2013 онд дэвшүүлээд үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд олон улс орныг хамарсан өргөн далайцтай ажлыг эхлүүлээд байгаа. Одоогоос 2000 жилийн тэртээ Ази болон Европ тивийг холбож байсан худалдааны замын маршрутыг орчин цагийн худалдааны шаардлагыг хангасан дэд бүтэц бүхий эдийн засгийн коридорууд бий болгох асар том төслүүд юм.

Эдгээр коридорын нэг нь Орос, Монгол, Хятадын нутгаар дайран өнгөрөх “АНЗ” 1000 км хурдны зам. Токиогоос эхэлж Истанбулд төгсөх олон улсын Азийн хурдны замын нэгдсэн сүлжээний нэг хэсэг “АНЗ” төслийн зам БНХАУ-ОХУ-ыг холбосон тээврийн зургаан коридорын хамгийн үр ашигтай нь гэгдэж буй. Тус зам ашиглалтад орсноор АН5, АН6 коридорын хурдны замын тодорхой хэсэг шилжин ирж Ази, Европын далайн боомтуудад хүрэх зайг 2700 км-ээр ▶

► богиносгон товчилно. Үр дүнд нь ачаа тээвэр 45, зорчигч тээвэр 34 цагаар хэмнэгдэнэ гэсэн тооцоо бий.

Ази-Европыг холбосон үр ашигтай эдийн засгийн коридор бий болгох санаачлагад гурван улс сонирхол нэгдэж байгаа юм. Тэр ч утгаараа Монгол Улсын Ерөнхийлөгч Орос-Хятадыг холбосон дэд бүтцийн томоохон төслүүдийн багц болох “Талын зам” санаачлагыг 2014 онд Душанбе хотноо болсон гурван орны төрийн тэргүүн нарын уулзалтаар анх удаа дэвшүүлэн тавьсан. Үүнд дурдсан “АНЗ” хурдны замаас гадна, төмөр зам, хийн хоолой, цахилгаан эрчим хүч болон газрын тосны шугам барих төслүүд багтаж байгаа юм.

Өнгөрсөн оны аравдугаар сард болсон Монгол-Хятадын анхдугаар Экспогийн нээлтийн үеэр БНХАУ-ын Шадар сайд Монгол Улсын санаачилсан “Талын зам төслийг бид дэмжиж байна. Гурван улсын хоорондын эдийн засгийн коридорыг мөн дэмжиж байна” хэмээсэн. ОХУ-ын зүгээс ч уг санаачлагыг дэмжиж байгаа бөгөөд хоёр улсын гүйцэтгэгч талууд “АНЗ” замын Монгол болон ОХУ-ын газар нутагт баригдах бүтээн байгуулалтад хамтран оролцохоор тохиролцоод буй.


Түүнчлэн нийслэл Улаанбаатар хот эдийн засгийн чөлөөт бүс болох юм. Ингэснээр хоёр тивийн бизнес эрхлэгчдийн цугладаг нэг төв нь Монгол байх боломжтой.

ASEM 11

Энэ удаагийн чуулга уулзалтуудаар ч мөн хоёр тивийн хамтын ажиллагаа гол сэдвүүдийн нэг болж байна. Өнгөрсөн сард болсон Сангийн сайд нарын уулзалтыг нээж Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэлсэн үгэндээ “ирээдүйн хүнд нөхцөл, хямралуудын нөлөөг зөөллөх үүднээс одоогийн макро эдийн засгийн сорилтуудтай нүүр тулахад илүү ахисан түвшний нарийн харилцаа хамтын ажиллагаа хэрэгтэй” гэсэн. Түүнчлэн ОУВС-гийн удирдах захирлын орлогч Мицүхиро Фүрусава Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нь зайлшгүй байгааг, мөн илүү нягт харилцан хамтрах нэгдмэл саналд хүрч дэлхийн, бүсийн болон хоёр талын харилцаагаа шинэчлэх хэрэгтэй байгааг онцолсон юм.

Европын Холбооны комиссын дэд ерөнхийлөгч Валдис Домбровскис энэ үеэр хөгжингүй орнуудын сэргэлтийн хувьд Азийн эдийн засгаас ихээхэн хамаарч байгааг чухалчлаад Европын хувьд Азийн эдийн засгуудад дараагийн үед орох шилжилтэд туслах бодлого, эдийн засгийн туршлага байгаа гэсэн. Тэрбээр “Илүү нягт хамтарч ажиллацгаая. Тэгвэл хоёр тивийн солилцооноос хоёул хожно” гэж хэлсэн билээ.

Мөн дөрөвдүгээр сард болсон Парламентын түншлэлийн есдүгээр уулзалтын нээлтийн арга хэмжээнд наймдугаар уулзалтыг зохион байгуулсан БНИУ-ын Парламентын Сенатын танхимын дарга Пьетро Грассо хэлэхдээ эдийн засгийн хямрал, тэгш бус байдал нэмэгдэж байгаа нь өнөө цагийн түгшүүрт үзэгдэл болж байна хэмээгээд өмнөх уулзалтаар “Нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэдэг гурван чиглэлд нийгмийн оролцоог нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийг дэмжихийг Засгийн газруудад уриалсан”-ыг ахин сануулсан билээ. ■



ТАЛЫН ЗАМ

2014 онд Душанбе хотноо болсон гурван орны төрийн тэргүүн нарын уулзалтаар Монгол Улсын Ерөнхийлөгч Орос-Хятадыг холбосон дэд бүтцийн томоохон төслүүдийн багц болох “Талын зам” санаачлагыг анх удаа дэвшүүлэн тавьсан.

“АНЗ” ХУРДНЫ ЗАМ

Токиогоос эхэлж Станбулд төгсөх олон улсын Азийн хурдны замын нэгдсэн сүлжээний нэг хэсэг “АНЗ” төслийн зам БНХАУ-ОХУ-ыг холбосон тээврийн зургаан коридорын хамгийн үр ашигтай нь гэгдэж буй. Тус зам ашиглалтад орсноор АН5, АН6 коридорын хурдны замын тодорхой хэсэг шилжин ирж Ази, Европын далайн боомтуудад хүрэх зайг 2700 км-ээр богиносгон товчино. Үр дүнд нь ачаа тээвэр 45, зорчигч тээвэр 34 цагаар хэмнэгдэнэ

ЭРЧИМ ХҮЧНИЙ КОРИДОР

БНХАУ эрчим хүчний хэрэглээ ирээдүйд улам өсөн нэмэгдэнэ. Тэр хэрэгцээгээ импортлоор хангах шаардлага тулгарч байгаа юм. Монгол Улсын Тавантолгойн болон ДЦС-V, Эгийн голын усан цахилгаан станц төслүүд эрчим хүч экспортлох боломжтой. Түүнчлэн Сибирьт үйлдвэрлэх шинэ эрчим хүчийг Хятад руу тээвэрлэх асуудал ч үүнд багтана.

ТӨМӨР ЗАМ

Төмөр замын хувьд Монгол улс 1953 оноос нэг үрсгалтай, даац багатай төмөр замаар хоёр хөршийг холбож байна. Энэ замаар Замын-Үүдээс Алтанбулаг хүртэл ачааг дунджаар 5-8 хоног тээвэрлэж буй нь хэт удаанд тооцогдож, энэ замыг хос төмөр зам болгох, улмаар хурдны галт тэрэгний зам барих асуудлууд яригдаж буй. Монголын төмөр замаар дамжин өнгөрөх тээврийн хүчин чадлыг жилд 100.0 сая тонн байхаар тооцож байгаа. Өнөөдрийн байдлаар манайд энэ хүчин чадал дөнгөж 2.0 сая тонн л байдаг.

ХИЙН ХООЛОЙ

Монголын нутгаар дамжуулан тээвэрлэхэд ердөө 1500 км хийн хоолой байгуулж, тэр чинээгээр хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэх боломжтой гэсэн тооцоо байна.

ГАЗРЫН ТОС

Манай улс сүүлийн жилүүдэд газрын тос олборлож байгаа. Гол түнш маань Хятад. Хойд талд Сибирийн газрын тосны асар их нөөц бий. ОХУ Манжуураар Хятадад газрын тос нийлүүлдэг. 2013 онд хийгдсэн 25 жилийн гэрээгээр 270 тэрбум ам.долларын газрын тос нийлүүлэхээр тохиролцсон. Эдгээр баялгийн урсгалыг дамжуулах нэг гол зангилаа нь Монгол. Боломжтой болохыг ч оросууд, тухайлбал “Роснефть” илэрхийлээд байгаа.

Ерөнхий сайдын дуулгасан дуулиантайхан баярт мэдээ тэр даруйдаа хэрүүлийн алим болж хувирав. “Эрдэнэтий овоо” шиг том стратегийн ордыг монголчууд “саалийн үнээ” гэдэг. Гэхдээ энэ удаад “бялуу” гэе. “Бялуу хуваах” гэх хэллэг мартагдах дөхөж.

Эрх мэдлийн тэмцэл, улс төржилтийн бай болдгоороо ч, эх орны эдийн засгийг нуруундаа үүрч явдгаараа ч тэр уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” хэзээнээсээ том “бялуу” байж ирсэн.

40-өөд жилийн турш энэ бялуунаас олон бизнес тэжээгдэж ирсэн нь нууц биш. Гэхдээ бялуунд хоёр том эзэн байсаар ирсэн нь Оросын болон Монголын Засгийн газар билээ. Харин Оросын тал гэнэтхэн өөрт ногдох хувиас татгалзсан нь бялууны хагас хэнд очих ёстой вэ? гэдэг асуулт бий болоод байна.

Гэхдээ гол асуудал аль хэдийнээ эзэн нь тодорчихсонд байв. Зургадугаар сарын 28-нд Ерөнхий сайд асан Ч.Сайханбилэг “Эрдэнэт” үйлдвэрийг 100 хувь Монгол Улс эзэмших боллоо гэж мэдэгдэхийн сацуу бялууны талыг эзэмшигч асан ОХУ-ын “Ростех” төрийн өмчит компани өөрийн мэдлийн

49 хувийг Худалдаа хөгжлийн банкны төлөөний компани “Монголын зэс корпораци”-д худалдсан болохыг мэдээлэв. Түүний хэлснээс бүх зүйл нэгэнт шийдэгдсэн гэж ойлгогдож байсан юм.

Тэрбээр хуулиар сонгуулийн сурталчилгаа хаагдсан өдөр ийн мэдэгдэл хийсэн нь санал татах гэсэн зорилготой бус Ерөнхий сайдын хувьд албан үүргээ гүйцэтгэж байна гэж тайлбарласан бөгөөд нөгөө талаас тухайн өдөр “Эрдэнэт” үйлдвэрийн дансыг хаасан гэх ташаа мэдээлэл гарсантай холбоотой гэсэн юм. Үүнээс 30 минутын дараа харин сөрөг хүчин мэдэгдэл гаргав. Тэд үүнийг “луйвар” гэж үзсэн юм. Асуудлыг улам хурцатгасан зүйл бол Эрдэнэтийн 49 хувийг худалдаж авсан гэх Худалдаа хөгжлийн банкны нийт хувьцааны 7.32 хувийг Америкийн “US Global investment” компани, 19.95 хувийг Америкийн “United Banking Corporation”, 4.78 хувийг “GS Mongolia investment”, 2.12-хон хувийг монголчууд, 65.83 хувийг нь Люксембурын “Global investment and Development” гэх оффшор компани эзэмшдэг гэсэн мэдээллийг тэд сэтгүүлчдэд өгсөн. ▶

Халуун сэдэв

Бялуу

Ц.БУЯН

Шинэ парламент бүрдэж, ажлаа эхэлсэнтэй холбоотой ийм эгзэгтэй үед “Эрдэнэт үйлдэр”-ийн даргаар хэнийг томилох бол гэдэг Ерөнхий сайдыг сонгохтой зэрэгцэн босож ирж, олны анхаарлыг татаж байна.



Уулын баяжуулан “Эрдэнэт үйлдвэр” 1978 онд байгуулагдсанаас хойш 38 дахь жилдээ ажиллаж байна

► УИХ-ын гишүүн Су.Батболдын хэлснээр уг 49 хувийг Засгийн өөрөө худалдан авч, дараагаар нь дотоодын компаниудад нээлттэй сонгон шалгаруулалт хийж хувьчлах ёстой байсан аж. Ингээд л хэн хэнтэй хэзээнээс хэлэлцэж, ямар хууль журмын дагуу Оросын тал “Монголын зэс корпорацид” хувьцаагаа худалдсан болох нь олон нийтийн сонирхлыг татаж байна. Зарим эдийн засагч, хуульчдын хувьд Компанийн тухай хуулиар нэг нь хувьцаагаа худалдахаар шийдсэн бол хамгийн түрүүнд компанийн бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгох ёстой аж. Түүнчлэн Монголын талын зөвшөөрөлгүйгээр өөр этгээд худалдах нь гэрээгээр боломжгүй зүйл болохыг УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр хэлж байгаа юм.

Үүнээс гадна өөр байр суурь илэрхийлэх хүмүүс ч цөөнгүй бий. Тухайлбал, эдийн засагч Д.Жаргалсайхан “Монголын зэс корпораци” 10 хувиас илүү хувьцаагаа авсан үнээр нь “Эрдэнэс Монгол” ХХК-д худалдаж, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийг яаралтай дэлхийн зах зээлд гаргах ёстой гэж үзэж буйгаа илэрхийлсэн. Харин эрх

зүйч Т.Бат-Оргил төр компани удирдаж компаниудтай өрсөлдөх хэрэггүй гэсэн байр суурийг илэрхийлж байна. Түүнчлэн “Эрдэнэт үйлдвэр” 100 хувь төрийн өмч байх ёстой гэж үзэх хүн олон байгаа бол эсрэгээрээ тус компанийн хувьцааг Эрдэнэс Тавантолгойн адилаар иргэн бүрт эзэмшүүлэх нь зөв гэсэн байр суурь ч дуулдах болсон.

Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирал О.Орхоны хувьд хэвлэл мэдээллийн байгууллагуудад өгсөн тайлбартаа бүх зүйл хуулийн дагуу гэдгийг хэлж байгаа. Гэхдээ хэлэлцээр хоёр жилийн өмнөөс эхэлсэн бөгөөд нууцын зэрэглэлтэй явж ирсэн гэх. Түүний хэлж буйгаар анх Оросын талаас санал тавьсан аж. ОХУ-ын ТАСС агентлагт мэдээлснээр “хэлцлийн үр дүнд “Ростех” корпораци өөрийн төсөвт түүхэндээ хамгийн их мөнгөн хөрөнгийг нэг дор оруулна” гэжээ. Түүнчлэн хэлцэл хоёр талд харилцан ашигтай нөхцлөөр хийгдсэн тухай дурдсан байна.

Гэхдээ Монголын Засгийн газар энэ бүх хугацаанд хэлцлийг яагаад чандлан нууцалж байсан нь тодорхойгүй байна. Түүнчлэн Оросын тал хувьцаагаа заръя

гэж байхад нь манайх авах нь зөв ч процедурын хувьд Монголын Засгийн газар асуудлыг ил нээлттэй хэлэлцэж, УИХ-аар оруулах учиртай юм.

О.Орхоны хувьд “хэлэлцээрийг нууцалсан нь олон улсын ийм томоохон хэлэлцээрт саад учруулах зах зээлийн болон бусад олон хүчин зүйл байсантай холбоотой. Тухайлбал, ОХУ, Казахстан, БНХАУ-ын компаниуд тус хувьцааг худалдан авах маш их сонирхолтой байсан” хэмээв. Харин асуудлыг УИХ-д оруулж танилцуулах үүргийг Засгийн газар хүлээж байсан боловч сонгуулийн үе таарч УИХ тарсан байсныг учирлаж байв.

Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” компанийн 49 хувийг “Монголын зэс корпораци” 400 сая ам.доллараар худалдан авчээ. Худалдаа хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн тухайд 65 хувийг эзэмшдэг “Global investment and Development”-ийг тус банкны ТУЗ-ийн дарга Эрдэнэбилэг 100 хувь эзэмшдэг, Монголд бүртгэлтэй компани гэдгийг О.Орхон “Монгол HD” телевизийн “Нүүдэл шийдэл” нэвтрүүлэгт оролцох үеэрээ хэлсэн юм. Тэрбээр мөн “тус банкны гадаад дахь хувьцаа эзэмшигч гэвэл зөвхөн “Goldman Sachs” 2012 онд тус банкны 4.8 хувийг худалдан авсан бөгөөд банкны 95.2 хувь нь цэвэр монгол иргэдийн өмч” гэлээ.

Өнөөдөр эрх баригч болсон МАН-ын хувьд асуудлыг шийдэгдсэний дараа бус бизнесийн гэрээ хэлцэл хийгдэхээс өмнө УИХ-д танилцуулж заавар зөвлөгөө авах ёстой байсан гэсэн байр сууриа хамгаалж байгаа. Ингэснээр Засгийн газар хөрөнгө босгож хувьцааг худалдан авах эсвэл хоёрдогч этгээдэд зарах бололцоог өнөөдөр нээж өгөх ёстой байсан аж. Энэ хэлцэлд зөвхөн “Эрдэнэт үйлдвэр”-ийн асуудлыг тусгаагүй. “Монголросцветмет” компани нь Асгатын мөнгөний орд болон хэд хэдэн ашигт малтмалын ордыг мөн эзэмшдэг юм.

Шинэ парламент бүрдэж, ажлаа эхэлсэнтэй холбоотой ийм эгзэгтэй үед “Эрдэнэт үйлдвэр”-ийн даргаар хэнийг томилох бол гэдэг Ерөнхий сайдыг сонгохтой зэрэгцэн босож ирж, олны анхаарлыг татаж байна.

Тэгэхээр энэ асуудлын өрнөл ирэх өдрүүдэд улам бүр хөврөх юм. Эцсийн үнэн зөв мэдээллийг бид эргэн уншигчдадаа хүргэх болно. ■



Аялал жуулчлал

Хүндхэн эхлэл, жаргалтай төгсгөл

Б.ЭНХЦЭЦЭГ

Тэрэлж байгалийн цогцолборт газарт сэргж, амьдралд ганц тохиох тэр л мэдрэмжийг авч Монгол оронд хийх аялал эхэлнэ гэж хэн хэзээ ч төсөөлж байгаагүй биз.



Хэдийгээр Бээжин-Улаанбаатарын хооронд нисэхэд хоёрхон цаг шаардагддаг ч цаг агаарын таагүй байдлын улмаас жуулчдын маань нислэг хойшилж урт удаан 10 цагийн аялал болгож хувиргав. Анх төлөвлөснөөр жуулчид маань үд дунд Улаанбаатар хотод бууж, хотоор хэсэг зуур аялсны дараагаар хотоос гарч Тэрэлж байгалийн цогцолборт газрыг зорих ёстой байлаа. Харамсалтай тэдний нислэг саатсанаар тэд нийслэл хотноо шөнийн нэг цагт газардаж, унтаж амрахын тулд шууд Тэрэлж рүү хоёр цаг шахам

машинаар явах шаардлагатай болсон юм. Жуулчдын маань бүлэг ихэвчлэн 50-иад насныхнаас бүрдэж байсан тул маш их ядарсан нь ойлгомжтой байлаа.

Гэсэн хэдий ч тэд дараах өдөр нь нүүдэлчдийн монгол гэрт сэрсэндээ баярлан билгэшээж байв. Шөнө дунд газардаж, сүүмэлзэх гудамжны гэрлээс өөр зүйл харж чадаагүй байсан жуулчдын маань хувьд амралтын баазын үзэсгэлэнт байгаль тэдний Монгол оронд ирээд харсан анхны “үзмэр” байлаа. Хүндхэн шөнийн дараагаар тэдэнд одоо л нэг өглөөний цэвэр агаар амьсгалж аяллаа эхлэх боломж олдлоо.

Анхны зогсоол болсон Тэрэлж байгалийн цогцолборт газар Улаанбаатараас 60 километрийн зайд орших бөгөөд уулархаг газар нутаг, олон төрлийн ан амьтнаар баялаг билээ. Нүүдэлчин айлаар зочилж, Мэлхий хадны байгалийн тогтоцыг үзэж, Чингис Хааны хөшөөний өмнө зураг авахуулах нь Монголд заавал үзэх ёстой зүйлд багтдаг. Цаашилбал явган аялал хийх, уул хаданд авирах, голд сэлэх, завь сэлүүрдэх, морь унах гээд нүд хужирлах зүйл мундахгүй. Улаанбаатар хотын оршин суугчдын хувьд ч Тэрэлж нь амралт чөлөөт цагаа өнгөрүүлэхээр зорих дуртай газрын нэг нь.

Энэхүү аяллын группын жуулчин Сильвер Уэнди “Бид Монголд шөнө дунд газардсан. Уг нь Улаанбаатар хотод нэг өдөр хонож, дараагаар нь хотоос гарч жуулчны баазад ирэх ёстой байсан юм. Нөхцөл байдлаас болж бид шууд бааз руу машинаар нэг цаг хагас хэртэй явж очих шаардлагатай болсон. Гэхдээ жуулчны баазын хүмүүс бидэнд маш сайхан хандсан. Тэд бидний амрах газрыг зааж өгч, шөнийн гурван цагт гал түлж өгсөн. Тэд маш сайн байсан” гэсэн юм. Мөн эл өдөр түүний төрсөн өдөртэй давхцаж аяллын компанийн зүгээс томоо гэгч төрсөн өдрийн бялууг түүнд бэлэглэж, мөн монгол гэрт төрсөн өдрөө утсан учир туйлын их баяртай байсан юм.

Аяллын хөтчөөр арваад жил ажилласан Б.Мөнхбат Америкаас ирсэн энэхүү жуулчдын группыг ахалж авсан юм. Түүний ахалж авсан группт АНУ-ын өнцөг булан бүрээс ирсэн найман жуулчид багтаж байсан бөгөөд тэд Монголд долоо хоногийн хугацаатай аялах байлаа. Аяллын группын хувьд Монгол бол Хятад улсад очихоос өмнөх зогсоол хэлбэрийн богино хугацааны аялал байсан юм.

Монголын тэргүүлэх аялал жуулчлалын компаниудын нэг болох “Нью Жуулчин турс” жил бүрийн зун ийм төрлийн аяллын бүлгийг АНУ-ын аяллын агентлагуудтай хамтран хүлээн авдаг аж. Хэдийгээр энэ группын гол аяллын цэг Монгол Улс ▶

► биш байсан ч заримдаа манай улс гол очих цэг нь болж, хөрш орнуудын хувьд гол цэгтээ очихоос өмнөх зогсоол болох тохиолдол байдаг.

Энэхүү АНУ-аас ирсэн групп аяллаа хүндхэн эхэлсэн ч Монголд хийж буй аялалдаа сэтгэл хангалуун байв. Тэдний төлөвлөсөн маршрут УБ-Тэрэлж-Өмнөговь-УБ гэж дуусах ёстой байсан юм. Хэдийгээр тэдний аяллын хөтөлбөр богино байсан ч нийслэл хотоос 500 километрийн зайд орших говь нутгийг маршрутдаа багтаасан нь сонирхол татаж байв. Өмнөговь руу онгоцоор цаг хагас нисээд л очдог. Гэсэн хэдий ч зарим тохиолдолд дотоодын нислэгийн саатал машинаар зургаан цаг давхихаас ч илүү хүндрэл учруулах нь бий.

Хөтөч Б.Мөнхбатын хэлснээр манай улсад ирсэн жуулчдад тулгардаг хамгийн түгээмэл асуудал бол дэд бүтэц, ялангуяа дотоодын болон олон улсын нислэг гэв. Үүнийг шийдэх нэг арга бол агаарын аялал жуулчлалын зах зээлд илүү олон тоглогчдыг өрсөлдүүлэх. Харамсалтай нь энэ удаад ч жуулчдын говь хүрэх нислэг мөн л саатаж, зорьсон газартаа арай гэж очтол тэднийг авч явах унаа эвдэрч өөр машинаар солих шаардлага тулгарав. Мөн унаагаа хүлээх зуур бүтэн өдрийн турш тог тасарлаа.

Говийн бүс нутгийн дэд бүтэц тэдний аяллын группын хувьд сорилт болж байлаа. Тэдний нисэх дотоодын нислэг саатаж 15 цаг хүлээлгэсэн нь арай л дэндсэн асуудал болсон бөгөөд нислэгийн багийнхан энэхүү саатлын бурууг цаг агаарт тохож байв. Харин унаа нь эвдэрсэн ч түргэн шуурхай өөр унаагаар үйлчилж, өдөржингөө тог тасарсан зэрэг асуудал жуулчдын маань аялалд тийм ч том асуудал үүсгээгүй юм. Үүссэн асуудлыг цаг тухайд нь оновчтой шийдэж, төлөвлөсөн хуваариа гүйцэж чадаж байсныг жуулчид сайшааж байв.

Жуулчдын олонх нь Монгол дахь аяллынх нь хамгийн оргил хэсэг бол говь байсан гэдэгтэй санал нийлж байв. Говьд ирэхийн тулд жуулчид маань үүрээр эртлэн сэрж Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот хүрэх дотоодын нислэгт суухаар ирэхэд нислэг саатаж тэднийг дахин хүлээлгэж, эцэж туйлдахад хүргэсэн. Гэвч эцэж туйлдсан жуулчдыг маань говийн гайхамшигт байгалийн тогтоц сэргээх мэт болов.

Тэд говьд гурван шөнийг өнгөрүүлсэн нь хангалттай амархын хажуугаар эслэн манхан, Баянзаг болон Ёлын амар аялж, тэмээ унаж, Говийн нуудэлчин гэр бүлээр зочлох боломжийг олгосон юм. Энэ нь Монголын аялал жуулчлалын гол бүс нутаг яалт ч үгүй мөн. Говь гурвансайхан байгалийн цогцолборт газар дахь Ёлын аманд болж байсан сарлагийн наадам тохиож буйтай санаандгүй таарсан нь жуулчдын хувьд гайхалтай гэнэтийн бэлэг байлаа.

Хаяа хязгааргүй мэт үргэлжлэх элсэн манхан, мөсөн бүрхүүл тогтсон хавцал, үлэг гүрвэлийн араг яс болон жингийн цуваа зэрэг нь Монголд ирсэн жуулчдын сонирхлыг яах аргагүй татдаг. Ёлын ам мөсөн тогтцоороо алдартай. Эндэх голын ус өвөл

хэдэн метр болтлоо зузаарч хөлддөг. Өмнө нь энэ газар бүтэн жилийн турш мөсөөр бүрхэгддэг байсан боловч сүүлийн жилүүдэд долдугаар сарын сүүлээр мөс нь хайлдаг болжээ.

Манай аяллын группын туршлагатай аялагчдын нэг болох Стефен Крокот “Би анх аялал захиалахдаа Монгол Улсыг гол аяллын маршрутаар сонгож Хятадыг хоёрдогчоор сонгох бодолтой байсан ч тийз захиалсан нислэгийн компанид асуудал тулгарч миний нислэгийг



цуцалсан. Үүний улмаас Хятадыг гол аяллаар сонгож Монголыг хоёрдогч болгон захиалах шаардлагатай болсон. Монголын гол зорих цэгээ болгосон нь цөл үзэх гэсэнтэй минь холбоотой. Би говийг удаан хугацааны турш үзэхийг хүсэж байсан. Харин говьд ирэх гол шалтгаан маань үлэг гүрвэл байсан ч мөн бусад цөлөөс ялгарах байдлыг үзэх нь чухал байсан” гэв.

Улаанбаатар хотод ирэх эхний нислэг саатсанаас болж алдсан тэдэнд хотын аялал хийх боломж аяллын сүүлийн өдөр олдов. Үдээш хойш нислэгтэй байсан ч Сүхбаатарын талбай, Гандан хийд, Занабазарын музей, Үндэсний түүхийн музейг үзэж, бага сага бэлэг дурсгалын зүйлс цуглуулж амжсан юм.

Ээж, охин хоёр болох Жанет болон Кристи Лакин хэлэхдээ Улаанбаатар хот тэдний төсөөлж байснаас илүү орчин үеийн болохыг хэлж байв. Бусад улсад хотоос гадагш гарахад иргэншилээс тийм ч их холддогийг тэд дурьдаж байлаа. Харин Монголын хөдөө о соёл иргэншилээс бүрэн тасрах боломжийг олгодог. Ямар ч чимээ аниргүй одод дүүрэн шөнийн тэнгэр, мөн найрсаг зочломтгой хүмүүс. Энэ бол Монголын хөдөө орон нутагт л бий.

Хэдийгээр тэдний аялал хүндхэн эхэлсэн ч Монголоос инээмсэглэл дүүрэн буцсан юм. Зарим нь Монголд илүү удаан хугацааг өнгөрүүлж чадаагүйдээ харамсаж, сэтгэл дундуур байлаа.

Монголын газар нутаг, ард түмэн жуулчдын урмыг хэзээ ч хугалдаггүй боловч хөгжил дэвшилтэй холбоотой зарим асуудал сэтгэл хөдлөлийг нь уруудуулах нь бий. Тийм боловч эдгээр нь засч болох хүчин зүйлс бөгөөд төд удалгүй шийдэгдэнэ гэдэгт найдаж байна. ■

Амьдрал

Английн Цэрэнбат

Д.БЭХЭЭ

*Униартан цэнхэртэх уулс толгодоо
Утаан нь алсаас харагдах бор гэрээ
Хойморт нь заларч гэр дүүргэх аавыгаа
Хошуу дэвсэн хүүгээ эрхлүүлэх ээжийгээ
Далай ихийг өгүүлэх нутгийн буурал өвгөдөө
Даахитай даага зайдагнасан балчирхан бага насаа
Самсаа шархиртал янцаалдах Монгол адуун сүргээ
Санаа сэтгэлийг ч амраагч талын бор салхиа
Санаж байна би санаж байна
Сэтгэл зүрхээ бэтгэртэл санаж байна...*

“Хурд” хамтлагийн энэ дууг монголчууд андахгүй. Ялангуяа эх орноосоо хол элэг нэгт ахан дүүс энэ л дууг дуулж, сэтгэл зүрхээрээ эх орноо санацгаадаг билээ. Монголчуудын чээжинд оршсон дууны эдгээр үгийг Английн Британи дахь монголчуудын холбооны Д.Цэрэнбат зохиожээ. 18 жилийн өмнө шүү. Түүний цахим анд Алтантулга дууны нийцүүлэн нэмж засварласнаар уг дуу төрсөн түүхтэй аж.



Д.Цэрэнбатын гэр бүл

Зах зээлийн эдийн засагт шилжсэн 90-ээд оны үед манай иргэд бүгд л Америк, Англи, Япон руу гарахыг хүсдэг байж. Виз ч чанга байсан тэр он цагуудад хилийн дээс алхсан олон аавын хүүгийн нэг бол Цэрэнбат. Холын орныг зорихдоо Английн иргэнийг эхнэрээ болгож, эх орондоо монгол заншлаараа сайхан хурим хийгээд тэр гадагш явсан юм. Энэ цаг бол 1997 он байлаа. Хүний нутаг, гүний хошуунд

суухдаа ижий аав, эх орноо санагалзан ээнэгшин дассан төрсөн нутгаа элэг зүрхнээсээ санахдаа дээрх шүлгийг бичсэн байдаг. 2000 оноос л бид интернэттэй танилцаж эхэлсэн болохоор холбоо харилцаа ямар байсан нь ойлгомжтой. Тиймээс ч эх нутгаа, аав ээжийгээ чээжиндээ бэтгэртэл санадаг байсан биз. Хурд хамтлагийн энэ дууны шүлэг бол монгол хүний чин сэтгэлийн угаас гарсан учраас олонд богино хугацаанд хүрчээ.

Ихэмсэг зан, язгуур угсаагаараа бусдаас ялгардаг Англи улсад Монголын нэгэн хүү амьдраад 18 жилийг ардаа үджээ. Аньсагандаа нулимстай Англи улсыг зорьж байсан үеийг бодвол тэр одоо буурь суурьтай, улс орныхоо хөгжлийн төлөө өөрөөс хамаарах бүхнийг хийж, хийхээр зүтгэж явна. 16 жилийн турш Цахим өртөө сүлжээг дэлхийн өнцөг булан бүрд буй монголчуудтай хамтран санаачлан үүсгэн байгуулж, хилийн чанад дахь ах дүүсийг эх оронтой нь мэдээллээр холбох үндсийг тавьсан юм. Цахим өртөөгөөр овоглодог олон залуу өнөөдөр улс орныхоо хөгжлийн төлөө томоохон албанд ажиллаж буйг харахад баяртай байдаг хэмээн Цэрэнбат ярих. Тэр эгэл жирийн монгол хүний төлөөлөл. Тиймдээ ч Лондонд амьдарч, сурч буй монголчууддаа тусалж дэмжихийг хичээж явдаг нэгэн. Зөвхөн Их Британи төдийгүй бусад орнуудад ажиллаж амьдарч буй монгол иргэд түүнийг танина, түүнд хүндэтгэлтэй хандана. “Хүмүүст өөрийн боломжоороо л туслахыг хүсдэг”. Энэ бол түүний зарчим.

Ингээд Английн Британи дахь монголчуудын холбооны Д.Цэрэнбаттай ярилцлаа.

-1990-ээд оны ардчиллын салхи сэвэлзсэн нийгэмд таныг гадаад хүнтэй гэрлэх салхийг эхлүүлсэн гэх юм?

-Надаас өмнө ч байсан зүйл шүү дээ. Удирдлагын академийн Я.Долгоржав багш маань “Чи Монголын гэр бүлийн түгжигдмэл байдлыг олон улсын түвшинд гаргаж тавилаа” шүү гэж тоглоом шоглоомоор хэлж билээ. Ийм тохиол харьцангуй цөөн, багшийн тоглож хэлснээр “түгжигдмэл” байсан цаг л даа.

-Танай эхнэр Монголд ямар ажил хийж байсан юм бэ?

-Антропологийн чиглэлээр Единбургийн Их Сургуульд докторын зэргээ хамгаалангуугаа дипломоо ч авалгүй Монголд

ирж ажилласан. Хүүхдийг ивээх сангийн шугамаар Нийгмийн хөгжлийн төв гэж мэргэжлийн зөвлөгөө өгөх төвд зөвлөхөөр гурван жил ажилласан. Ядуурлыг бууруулах төслийн багийн анхны гишүүн. Монгол хэл заалгаад чамгүй сайн сурчихсан, ажлынхаа шугамаар манай орны 19 аймгаар явчихсан хүн дээ.

-Та хоёрын хувьд сэтгэлгээний зөрүү их байсан уу? ▶

► - Биесээ ойлголцоод, ёс заншлуудаа хүндэтгээд харилцан хүлээцтэй байваас бололгүй дээ. Ижил орчин ахуйд өссөн хоёр хүнд ч нийлж амьдрал зохионо гэдэг амаргүйг бүгд мэднэ. Хосолж амьдрахын талаар “Нэг хүн хоёр болохын зовлонг давбаас хоёр хүн нэг болохын жаргал” гэж би нэгэнтэй бичиж байсан.

-Англичууд ямар хүмүүс вэ?

-Гэр бүлийн хүнээсээ, эргэн тойрноосоо л харж анзаарснаа хэлж чадах юм. Тэд гэр бүлээ тэргүүн эгнээнд тавина. Цаг баримтална. Ажлаа үнэн сэтгэлээсээ хийх дадалтай, их элгэмсүү, хүлээцтэй ард түмэн.

Бусдаас үл хамааралтай ажиллаж, амьдрахыг хүсдэг хүмүүс. Тэр нь жаахан сөрөг дагавартай ч нийгмийн тогтолцоо, чиг хандлага нь тийм болгодог.

-Тус орны боловсролын системийн чанар юунд байна вэ?

-Бага насны хүмүүжил боловсролоос л эхэлдэг. Сургуулийн өмнөх наснаас нь хүүхдүүдийг бие даалгах, өөрийгөө илэрхийлэх чадвартай болгоход ихэд анхаардаг юм билээ. Англи хүний үнэ цэнийг бий болгох, мэдрүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлдэг. Шашинд багагүй анхаарна. 3,4-р анги хүртэл нь шашны зан үйлээр зөв хүмүүжил олгох, өөрөөр хэлбэл, хүүхдийг багаас нь өөрийн үзэл баримтлалтай, түүндээ итгэл төгс байлгах хүмүүжлийг өгч байна. Анги ахиад шинжлэх ухааны ойлголтууд өгсөн хичээлүүд ороод ирэхээр хүүхдүүд шашин, шинжлэн ухааны асуудлыг ялгаж, салгаж ойлгоод ирнэ. Мөн эцэг эхийн оролцоог түлхүү байлгаж, хамтран ажилладаг нь анхаарал татдаг. Охиныхоо шинэ сургуулийн танилцуулах хуралд суугаад ирлээ. Эрх барьж буй намаас сургуулийн төсвийг танаж буйтай холбогдон 2000 гаруй сурагчтай 200 гаруй багш ажилтантай энэ том сургууль 1 сая фунтийн төсөв сох алга болж буйг захирал нь хэлж танилцуулж, эцэг эхийн нийгэмлэгийн ахлагч нь харин энэ хүнд байдлаас хамтдаа яаж гарах арга замууд байгаа талаар саналаа хэлж байх жишээний. Мэдээж тэд сая фунт босгож чадахгүй ч нэгэнт тулгарч буй бэрхшээлийг нээлттэй ярилцаад хамтын хүчээр сургалтын чанараа алдагдуулалгүй давахыг хичээж байна. Сургууль, эцэг эх ингэж хамтарч ажилладаг.

-Тэгвэл эрүүл мэндийн хөгжлийн тухайд?

-Английн эрүүл мэндийн тогтолцоо нь үнэгүй. Үнэгүй болохоор эмчилгээнд найдаад биеэ зөнд нь орхих хандлага байдаг. Мөн өвчний онош гартал нэлээд цаг алдах талтайг нийтээрээ шүүмжилж буй нь харагддаг. Иймээс иргэдээ өвдөхөөс урьдчилан сэргийлэхэд багагүй анхаарлаа хандуулж байна.

Зах зээлийн зарчмаар үнэтэй хувийн эмнэлгүүд байдаг. Хүмүүсээ эрүүл орчинд амьдруулах орчныг бүрдүүлэх хууль тогтоомжууд нь хүний эрүүл мэндийг сайтар хангах, стандартуудтай. Тэр стандарт, дүрмийн дагуу иргэдэд үйлчилнэ.

-Танай хүүхдүүд монголоор ярьдаг уу?

-Хоёр хүүхэд маань Монголоор ярихдаа сайнгүй ч сэтгэлийг нь монголжуу болгох гэж хичээж л байна. Хичээл сургууль дээрээ гадаад орны тухай ярих бичих зүйл гарвал Монголоо жишээ болгож бэлдэж байгаа

нь харагддаг. Бяцхан ном хийх бол Чингис хааны тухай сэдвийг сонгох жишээний. Би машинд монгол ая дуу ихэнхдээ сонсож явдаг. Манай хоёр хааяа “өөр дуу тавиач” гэж байгаа л байдаг юм. Чихэнд нь дасаж сэтгэлд нь урсаж орж байг гэж боддог юм.

Хоёр жилдээ нэг зуны амралтаараа Монголд өвөөгийнхдөө очно. Хөдөөгийн элдэв санаа зовох зүйлгүй амар амгалан орчныг үгүйлж ярих нь элбэг. Монголын хөдөө бол хүүхдийн хувьд амар амгалан, эрх чөлөө юм.

-Монголдоо бүр ирж амьдрах бодол бий юу?

-Бодолд байдаг зүйлийн нэг. Хүүхдүүдийн сургууль соёл нэг тийш болог, бас гэр бүлийн хүнийхээ санаа бодлыг сонсож ярилцаж шийдэх хэрэгтэй болно доо.

-Гадаад дахь монголчууд харьяаллын асуудлыг их хөндөж ярьдаг? Энэ талаар ямар бодолтой явдаг вэ?

-Улс орныхоо үндэсний аюулгүй байдлыг хүндэтгэж үзнэ. Мөрдөгдөж буй хууль журмаа дагахаас аргагүй. Гэхдээ гаднын иргэншил авчихсан монголчууд хэдэн мянгаараа бий болсон нь нууц зүйл биш шүү дээ. Уг нь олуулаа болохыг хүсдэг улс энэ бодит байдлыг харж эрх зүйгээ зөв зохицуулаасай гэж боддог. Цахим Өртөө холбоо өөрийн шугамаар энэ асуудлыг олон жил ярьж янз бүрээр л үзэл бодлоо илэрхийлж ирсэн. Шийдэх цаг нь ойртож байгаа байх гэж найдаж байна.

-Монголын хөгжлийн тухай бодлоосоо хуваалцахгүй юу?

-Хүний хөгжлөөс улсын хөгжил үүдэх ч төрийн бодлого зохицуулалтаас хүний хөгжил хамааралтай гэж боддог. Өнгөрсөн 25 жилд бид хүнээ мартчихсан байна гээд залуус яриад эхэллээ. Бүр зөв хүнийг хүртэл буруу болгож хүмүүжүүлээд байгаа тогтолцоо бүрдчихсэн санагддаг. Хөгжилд гарч буй доголлын шалтгааныг энэ залуус зөв харж томьёолсон санагддаг. Улсын хөгжил хүнээ зөв хөгжүүлэх төрийн бодлого, эрх зүйн тогтолцоо, гүйцэтгэх засаглалтай байхаас үүдэлтэй. Түүний дараа хөгжлийн тухай яривал илүү зохистой болов уу?

Хилийн чанадад суугаа бид гэхдээ зүгээр суухгүйг хичээж байна. Монголчуудынхаа оюуны эрч хүчийг бас улс орныхоо хөгжил дэвшлийн зүгт чиглүүлэх зорилгоор Лондонгоос эхтэй “Монгол орны хөгжилд” чуулга уулзалтыг гадаад улс орнуудад 2005 оноос хойш тасралтгүй 12 жил хийлээ. Элчин сайдын яамдынхаа нягт хамтын ажиллагаа дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг энэ чуулган маань эх орноо хөгжүүлэх бодол хүсэлтэй оюунлаг залуусын уулздаг танилцдаг, хойшдын ажил үйлсийг хамтран хийх гүүр болж, төр засгаас дэмжиж хамтран ажилладаг хэмжээнд хүрч буйд баяртай байдаг.

Хэн бүхэн аливаа зүйлд оюунлагаар хандаж байгаасай. Ялангуяа энэ үнэн худлын барьцгүй мэдээллийн их урсгалын дунд “хүн” байхын дархлаа нь хэр оюунлаг байхаас илүү их хамаарах болоод байна. Орчин үед социал ертөнцөөр нүүр ном ухаад байхаас оюуны бүтээл, хэвлэмэл ном уншдаг хүн тоотой болж. Британийн монголчуудынхаа дунд олон ►

▶ салбарын эрдэм номтой хийсэн бүтээсэн зүйлтэй хүмүүстэй уулзаж санал бодлыг нь сонсож, улам бүр оюунлаг байхад нь тус болох зорилгоор манай залуус “Оюунлаг Оршихуй” цувралыг Элчин сайдын яамныхаа дэмжлэгтэйгээр зохион байгуулж гурван жилийн хугацаанд 33 дугаар хийгээд буй. Ирж оролцдог хүмүүстэй үр өгөөжөө өгч байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Миний хувьд энэ цуврал уулзалтаас их зүйл мэдэж, ойлгож буй.

-Таны бахархал юу вэ?

-Монголчууд оюуны өгөгдөл өндөртэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг, битүүхэн бахархдаг. Олон улсын чанартай оюуны төрлийн шатар, даам, санах ойн багтаамж, хурд шалгаруулах гэх мэт олон уралдаан тэмцээнд монгол хүүхдүүд байнга л тэргүүн байр эзэлж байна. Гэтэл тэр хүүхдүүдийн оюуны эгөгдөл насанд хүрээд ирэхээрээ алга болчихдог шиг тогтолцоо байгаа нь л харамсалтай. Тэр өгөгдлийг л бодлогоор цааш нь хөгжүүлээд аваад явдаг тогтолцоо бий болоосой гэж боддог. Тэгвэл бидний бахархал юм илүү бодитой барьцтай болно доо.

Ерөнхийлөгч асан Н.Багабанди гуай 1998 онд нэг удаа “Бахархах юмгүй үндэстэн хөгжиж дэвждэггүй” гэж хэлснийг тэр үеийн “Өдрийн сонин”-оос уншиж байсан. Гэтэл бас бахархаад байгаа гэж ойлгож буй зүйлээрээ зөв бахархаж чадахгүй бол хөгжиж дэвждэггүй л юм шиг байна.

Ер нь бахархал гэдэг харьцангуй ойлголт санагддаг. Барбадос гэж олон жил Английн колони байсан арал улсад нэг жил амьдарсан юм. Эрээвэр хураавар тэр улсын ард түмэнд манайх шиг түүх гарлаараа бахархаад байх юм байхгүй. Гэхдээ бид нарлаг сайхан байгальтай найрсаг зочломтгой ард түмэн гэж өөрсдөөрөө бахархаад дуулаад бүжиглээд, жуулчлалыг зөв бодлогоор эрчимтэй хөгжүүлээд, Карибийн бүс нутагтаа өндөр хөгжилтэйдөө тооцогдох болтлоо өндийснийг харж болно.

-Англи руу явахаас өмнө та хаана ажиллаж байсан бэ?

-1991 онд МУИС-ийг математикч мэргэжлээр төгссөнөөсөө хойш 97 оныг дуустал Удирдлагын Академид шийдвэр гаргах тоон аргууд, статистик менежментийн хичээл заадаг байсан.



Тэр эх орондоо жил бүр ирдэг. Чингис хаан онгоцны буудалд буунгуут хөдөө рүү л тэмүүлдэг. Төв аймгийн Алтанбулаг суманд 70 гарсан аав, ээж нь бий. Багадаа тоглож өссөн уул толгод нь урьдын адил дотно угтан авна. Тиймээс л хүү нь төрсөн нутгаа яаран яаран очиж, ургын урт уужим амьсгаа авч, амар амгаланг мэдрэхийг хүснэ. Адуу малтай хөөцөлдөж, аргал түүж, эмээ өвөөдөө тусалж явсан хүүхэд насаа дурсана. Гэгээн байх үеийн бүх зүйлс гэгээнээр үлддэг.

Хилийн чанад дахь монголчууд эх орноо илүү санаж хайрлаж, хамгаалахыг хичээдэг. Хүний нутагт очоод өөрсдийн алдаа оноогоо ухамсарлаж, ирээдүйгээ харж, төлөвлөдөг. Алсрахаар эргэж дурсамжаа сэргээдэг, мөрөөддөг. Зайнаас өөрсдийгөө харж, гэгээн дурсамжаа сэргээж, гэгээлэг мөрөөдлөөр амьдардаг хэмээн Цэрэнбат ярих.

Тэр тооны мэргэжилтэй ч толгой холбосон шүлгүүд олонтой. “Би шүлэг бичдэггүй шүү дээ. Бодлын дуслууд гээд өөрийн анзаарсан бодсон зүйлсээ эргэж санаад задалж шинжилж байхад дөхөм болгож, хоёр, гурван мөрөөр буулгадаг. Бодрол талдаа” гэсэн юм. Зарим нэг бодролоос нь сонирхуулья.

Санаа зорилгоо явах зүгээ болгон зам тат, гажихгүйг хичээ Шалих шалихгүй замын явалдал бага элээд бөмбөрцөг хэлбэри.

Бодол сэтгэлээ нээлттэй байлга, болзол төсөөллөөр бүү хүл Бурруугийн угт зөвийн учиг байдгийг тунгаа Бултаар зөвтгөх зүйл ч буруудаг болдгийг сана Үнэний төлөө гэж бүү хашигар Өөрөө тэр чинь байнга хувирч байдгийг ухаар Эргэлдэж байдаг шигээ бөөрөнхий энэ хорвоод Эргэлзэх хэрэггүй дээ, өнөөдрийн үнэн маргаашийн худал болдогт бүү гайх

Эрэг шураг амьгүй - Нийлүүлж угсраад машин бүтээх “амархаан”. Учир нь арга ухаан нь нэг л номд багтаж болмой. Харин Эрдэнэт хүмүүн дор бүрдээ тусгаар амьдрал - Нэгэн зорилгод нэгтгэн удирдах “амаргүй ээ”. Учир нь мянган ном шүүгээд ч яг таарах “жор”-ухаан эс олдмой.

Бодолд хургах муу муухайг умартан зайлуулья Болж бүтэхийн сайн сайхныг дуудан залбирья Өөрсдөө ямагт гэгээн сэтгэлийг чандлан эрхэмлээ Үрс хойчдоо балчир нялхаас нь зөв сэтгэлийн үр суулгая

Улсын баяр наадам дөхжээ. Цэрэнбат Лондон дахь монголчуудынхаа үндэсний баярыг жил бүр зохион байгуулалцдаг. Өөрөө гол дүрд нь хувирах тохиолдол цөөнгүй. Залуудаа барилдаж сумын заан хүртэл цолыг хүртэж явсан тэрбээр өдгөө бөхөө засна, тайлбарлана, цол дуудна. Улсын баяр наадам ойртох тусам сэтгэл гэгэлзээд ирдэг хэмээн ярьсан юм. Монгол наадмаа харийн нутагт тэмдэглэн, ёс заншил, ахуй соёлоо хадгалан үлдэх сурталчлан таниулах ажлыг гадаадад суугаа монголчуудынхаа нэгэн адил тэр Элчин сайдын яам, санаа зорилго нэгт нөхөдтэйгөө хамтран хийсээр. ■

Судалгаа

Монголын залуучуудын улс төрийн оролцооны өнөөгийн байдал

С.ЗУЛЬФИКАР /доктор, дэд профессор

(Удирдлагын академийн улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч)


Төгсгөл. Түүрүүч нь №12 (114) дугаарт

Эмпирик судалгааны үр дүн

Энэ оны гуравдугаар сарын 1-нээс тавдугаар сарын 1-ний хооронд Удирдлагын академийн судалгааны баг 18-35 насны залуучуудын улс төрийн оролцооны түвшин, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох судалгаа явуулж, онол-практикийн тайлбар хийх бололцоо бүрдсэн. Судалгааны баг Монгол Улсын бүс нутгийг төлөөлүүлэн орон нутгаас гурван аймаг (Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий)-ийн 622 залуучууд, Улаанбаатарын есөн дүүргийг төлөөлүүлэн гурван дүүрэг (Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх)-ийн 429 залуучуудыг тус тус түүвэрлэн судалгаанд хамруулсан.

2013 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын тоо 2 870 897 байсан бөгөөд 18-35 насны залуучууд 1051440 буюу 36,7 хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан залуучуудын 12,9 хувь нь 18-20 насныхан, 25,2 хувь нь 21-25 насныхан, 33,2 хувь нь 26-30 насныхан, 28,6 хувь нь 31-35 насныхан байна (График 1-ийг үзнэ үү).

График 1. Судалгаанд хамрагдсан залуучууд (насны бүлгээр)




Судалгаанд хамрагдсан залуучуудын 48 хувь нь эрэгтэйчүүд, 52 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь хүйсийн төлөөлөл зохистой түвшинд хангагдсан болохыг харуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд судалгаанд

хамрагдсан гурван залуу тутмын нэг буюу 31.3 хувь нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцоогүй буюу ажилгүй, суралцдаг, эсвэл тэтгэмжид хамрагддаг залуучууд байна. Харин үлдэх 68.7 хувь нь ямар нэгэн орлого, цалинтай ажил эрхлэгчид байсан ба эдгээрээс хамгийн өндөр хувийг буюу 43.7 хувийг цалин хөлстэй ажиллагчид бүрдүүлсэн. Судалгаанд хамрагдсан залуучуудын 15.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.3 хувь нь ажил олгогчид байсан бол 4.9 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн, мал аж ахуй эрхлэгч, өрхийн үйлдвэрлэлд цалин хөлсгүй оролцогчид байв. Судалгаанд хамрагдсан залуучуудын тоон болон чанарын төлөөллийг зохистой түвшинд хангасан байдлаар түүвэр судалгаа явуулсан байна.

Залуучуудын улс төрийн оролцооны түвшинг тодорхойлох асуултанд 1/3 нь улс төрд огт оролцдоггүй гэж хариулсан бол 57.6 хувь нь зарим үед оролцдог гэжээ (График 2-оос үзнэ үү). Өөрөөр хэлбэл гурван залуу тутмын 2 нь улс төрд оролцохгүй байгаа нь судалгааны үр дүнгээс тодорхой байгаа юм.

График 2. Залуучуудын улс төрийн оролцооны түвшин




Залуучуудын улс төрийн оролцооны түвшингийн дундаж утгын коэффициентийг 1-3 гэсэн интервалаар тооцож үзэхэд 1.72 гарчээ. Дундаж

утга нэг рүү ойртох тусам улс төрийн оролцоо буурах бол гурав руу ойртох тусам улс төрийн оролцоо нь нэмэгдэх юм. Үүнээс үзвэл залуучуудын улс төрийн оролцооны түвшин харьцангуй сул байгаа нь тогтоогдож байна.

Залуучуудын улс төрийн оролцоонд тэдний нийгэм-эдийн засгийн байдал нөлөөлж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх явцад сонирхолтой үр дүн гарсан юм. Тухайлбал, судалгаанд хамрагдсан залуучуудын улс төрийн оролцооны түвшинд насны бүлгээр нь дүн шинжилгээ хийхэд нас нэмэгдэхийн хэрээр оролцоо ямар нэг байдлаар нэмэгдэх зүй тогтол ажиглагдсан. Насын мөчлөгийн онолоор иргэдийн улс төрийн оролцоо нь тэдний наснаас хамаардаг гэж үздэг. Иймд судалгаанд хамрагдсан залуучуудын нас улс төрийн оролцоонд нь тодорхой түвшинд нөлөөлж байгаа нь тогтоогдсон болно (График 3-аас үзнэ үү).

График 3. Улс төрийн оролцооны түвшин насны бүлгээр (дундаж)



Үүний нэгэн адил хүйс залуучуудын улс төрийн оролцоонд нөлөөлөх хүчин зүйл болж байгаа нь тогтоогдсон. Залуучуудын хүйсээс улс төрийн оролцооны түвшин хэрхэн хамаарч байгаад статистик боловсруулалт хийхэд корреляцын коэффициент 0.72 ▶

▶ гарч байгаа болно. Энэ нь залуучуудын улс төрийн оролцоонд хүйс мэдэгдэхүйц нөлөөлдөг гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Эмэгтэйчүүдийн гэр бүлийн үүрэг нь тэдний нийгэм-эдийн засгийн байр суурийг тодорхойлох шинжтэй байдаг бөгөөд улмаар улс төрийн оролцоонд ямар нэг байдлаар нөлөөлдөг. Учир нь эмэгтэйчүүд хүйсийн онцлогоос үүдэн хүүхэд төрүүлэх, асрах, гэрийн ажил хийх үүрэг хүлээдэг нь тэдний улс төрд оролцох бололцоог хязгаарладаг.

Залуучуудын оршин сууж байгаа газрын байршил, ажил эрхлэлт нь тэдний улс төрийн оролцооны түвшинд нөлөөлөх хүчин зүйл болж байгаа нь мөн адил ажиглагдсан. Тухайлбал, ажил олгогч, нөхөрлөл хоршооны гишүүдийн улс төрийн оролцоо харьцангуй өндөр буюу оролцооны дундаж утгын коэффициент нь 1.80, 2.00 байв. Өөрөөр хэлбэл ажил эрхлэлтийн байдлаар тооцсон дундаж утга нь залуучуудын улс төрийн оролцооны дундаж утгаас даруй 0.20-0.30 пунктээр өндөр байна. Нийгмийн тодорхой бүлгийн ажил, амьдралд улс төрийн үйл явц нөлөөлөхийн хэрээр тэндий улс төрийн оролцоо нэмэгддэг бөгөөд энэ зүй тогтол судалгааны үр дүнгээс мөн адил ажиглагдаж байна.


Залуучууд улс төрд ямар хэлбэрээр оролцож байгааг тодруулахад 70.8 хувь нь сонгуульд оролцдог, 40.7 хувь нь фэйсбүкээр санал бодлоо илэрхийлдэг, 20.2 хувь нь твиттерээр санал бодлоо илэрхийлдэг гэж хариулжээ (График 4). Сонгууль бүх насны иргэдийн хувьд улс төрийн оролцооны түгээмэл хэлбэр болдогтой адил залуучуудын хувьд үүний нэгэн адил дүр зураг давтагдаж байна. Харин залуучууд цахим орчноор дамжуулж улс төрийн үйл явцад илүүтэй




оролцдог онцлогтой байв. Нийгмийн сүлжээ (social media)-ээр дамжуулж мэдээлэл авах, түгээх боломж хурдтай нэвтэрч, түгэн дэлгэрч байгаа нь залуучуудын хувьд улс төрийн оролцоо давамгайлах сонголт болжээ.

Залуучуудын улс төрийн оролцоо мэдэгдэхүйц сул байгаа нь тэдний насны онцлог, нийгмийн сонирхол, өвөрмөц хэрэгцээнээс үүдэлтэй гэдэгтэй судалаганы баг санал нэгдэж байгаа юм. Учир нь залуучуудын хувьд сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, орлоготой болох, гэр бүл болох, өөрийгөө хөгжүүлэх, ажлын дадлага туршлага суух гэх мэт тэргүүлэх ач холбогдолтой хүсэл сонирхол хэрэгцээ байнга тулгамдаж байдаг. Ийм тэдний нөхцөлд улс төрд оролцох сонирхол нь ихэвчлэн сул байдаг. Хэдий тийм боловч залуучуудаас улс төрд оролцохгүй байх ямар учир шалтгаан байгааг тодруулахыг хичээсэн.

Судалгаанд хамрагдсан залуучуудын 20.9 хувь нь итгэл хүлээсэн нам, улс төрч байхгүй, 17.9 хувь нь сонгуульд санал өгөх насанд хүрээгүй байсан, 13.7 хувь нь улс төрд итгэдэггүй, 11.5 хувь нь улс төр сонирхдоггүй гэсэн үндэслэлийг улс төрд оролцохгүй байх шалтгаан болгон хариулжээ (График 5). Гадны улс орнуудад хийсэн судалгаагаар улс төрийн нам, улс төрчид сонгогчдын итгэл хүлээж чадахгүй байгаагаас иргэдийн улс төрийн оролцоо суларч байгаа нь мөн тогтоогдсон байдаг. Үүний нэгэн адил манай залуучуудын хувьд улс төрийн нам, улс төрчид сонгогчдын итгэл хүлээхгүй байгаа нь тэдний улс төрийн оролцоонд сөрөгөөр нөлөөлдөг гэсэн дүгнэлтэд хүргэж байна.



Судалгааны хүрээнд улс төрийн оролцооны түгээмэл хэлбэр болох сонгуульд залуучууд ямар түвшинд оролцож байсан хийгээд оролцохоор байгааг тодорхойлох зорилт тавьсан. Залуучуудын 77.6 хувь өмнө нь сонгуульд ямар нэг байдлаар оролцож байсан гэж хариулжээ. Ямартай ч залуучууд сонгуулийн талаар тодорхой төсөөлөлтэй байдаг гэсэн эхний дүгнэлтэд хүргэж байна. Улмаар 2016 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох эсэхийг тодруулахад 71 хувь нь оролцоно гэж хариулсан. Үүнээс үзвэл судалгаанд хамрагдсан 3 залуу тутмын 2 нь сонгуульд оролцох юм байна гэж үзэж болохоор байна. УИХ-ын 2012 оны ээлжит сонгуульд 18-35 насны залуучуудын ирц 41.5 хувьтай байсан (сонгуулийн ирц 65.8 хувьтай) -тай харьцуулахад залуучуудын сонгуулийн ирц нэлээд өндөр байхаар төсөөлөгдөж байна.




Залуучуудын сонгуулийн оролцоо мэдэгдэхүйц өндөр байхаар төсөөлөгдөж байгаа нь ямар учир шалтгаантай вэ? Залуучуудын сонгуулийн оролцоо өндөр байх нөхцөл юу вэ? Улс төрийн практикт аливаа улс оронд нийгэм - эдийн засаг - улс төрийн хямралт байдал давхацсан цаг үед нийгмийн бүлгүүдийн улс төрийн идэвх сэргэж, сонгуулийн ирц нэмэгддэг зүй тогтол ажиглагддаг. Улс төрийн бодлого, шийдвэр, эрх баригчдын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа иргэдийн амьдралд сөрөгөөр нөлөөлөхийн хэрээр сонгогчид богино хугацаанд тэрхүү үйл явцын эсрэг хариу үйлдэл үзүүлдэг байна. 2012-2016 онд улс орны хэмжээнд эдийн засгийн хямрал газар авч, ▶

► ажилгүйдэл нэмэгдэж, амьжиргааны түвшин доройтсон нь залуу сонгогчид шинэ сонголт хийх, улмаар улс төрийн хямралыг даван туулах шинэ бодлого хүсэмжлэх шалтгаан болсон бололтой. Иймд сүүлийн дөрвөн жилд өрнөсөн нийгэм - эдийн засаг - улс төрийн хямрал залуучуудын сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх суурь нөхцөл болсон гэж дүгнэж болохоор байна.

Залуучуудын сонгуулийн оролцооны дундаж утга 2.62 байгаа бөгөөд энэ нь сонгуулийн ирц мэдэгдэхүйц өндөр байж болохыг илтгэн харуулж байна. Харин тэдний нийгэм - эдийн засгийн хүчин зүйлс сонгуулийн оролцоонд нь харилцан адилгүй байдлаар нөлөөлөхөөр байгаа нь судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийх явцад ажиглагдаж байгаа болно. Тухайлбал, залуучуудын боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр тэдний сонгуулийн оролцоо бага багаар нэмэгдэх зүй тогтол ажиглагдсан. Өөрөөр хэлбэл боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр сонгуулийн оролцооны дундаж утгын коэффициент 2.11 пунктээс 2.64 пункт болон нэмэгдсэн (График 7-г үзнэ үү).

График 7. Сонгуулийн оролцооны дундаж утга (боловсролын түвшингээр)



Хувь хүний боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр хүмүүсийн улс төрийн оролцоо нэмэгдэх зүй тогтол ажиглагддаг. Учир нь тухайн хүн өөрийн мэдлэг, боловсролоор дамжуулан мэдээлэл олж авах, боловсруулах, улс төрийн үйл явцад бодитой үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой болдог байна⁷. Харин боловсролын түвшин доогуур байхын хэрээр улс төрийн оролцоо нь буурдаг ажээ. Боловсролын түвшин нь хувь хүний ажил, мэргэжил, нийгмийн орчин, нийгмийн байр суурийг тодорхойлох шинж чанартай тул үүнтэй

уялдан улс төрийн идэвхтэй эсхүл идэвхгүй бүлэгт багтах шалгуур болно. Ийнхүү залуучуудын боловсролын түвшингээс хамаарч тэдний сонгуулийн оролцоо ялгаатай байдаг тухай онол арга зүйн дүгнэлт эмпирик судалгааны үр дүнгээр нотлогдож байгаа юм.

Ажил эрхлэлтийн байдал нь залуучуудын сонгуулийн оролцоонд тухайлан нөлөөлж байгаа нь судалгааны явцад тогтоогдсон. Ажил олгогч болон нөхөрлөл, хоршооны гишүүн залуучуудын улс төрийн оролцооны дундаж утгын коэффициент маш өндөр (2.71-3.00) гарсан (График 8-ыг үзнэ үү). Өөрөөр хэлбэл ажил мэргэжлийн хувьд эдгээр бүлэгт хамаарах залуучууд 2016 оны УИХ-ын сонгуульд бараг 100 хувь оролцохоор дүр зураг төсөөлөгдөж байна. Энэ нь тэдний бизнес, ажил хэрэгт энэ удаагийн УИХ-ын ээлжит сонгуулийн үр дүн маш чухал болохыг илтгэж байгаа юм.

График 8. Сонгуулийн оролцоо болон хөдөлмөр эрхлэлтээр (дундаж утга)



Энэ зүй тогтолыг шалгах зорилгоор хоёр хувьсагчийн хамраалын тооцоолол хийж үзсэн. Ингэхэд R утга нь 0.044 буюу ач холбогдолтой байгаа бол корреляцын коэффициент 0.62 буюу мэдэгдэхүйц нөлөөтэй гэсэн утга илэрхийлж байна. Ямартай ч залуучуудын ажил мэргэжил болон сонгуулийн оролцооны хооронд мэдэгдэхүйц хамаарал байгаа нь маш тодорхой тайлбарлагдаж байна.

Ийнхүү Монголын залуучуудын улс төрийн оролцоог судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэвэл дараах дүгнэлт гарч байна. Үүнд:

- 18-35 насны залуучуудын улс төрийн оролцоо харьцангуй сул (статистик дундаж утга нь 1,72) байна. Гурван залуу тутмын нэг нь улс төрд огт оролцохгүй байна.

- Залуучуудын улс төрийн оролцоонд хүйс мэдэгдэхүйц түвшинд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

- Залуучуудын ажил эрхлэлт, нас, оршин суугаа газар нь улс төрийн оролцооны түвшинг тодорхойлох зүй тогтол ажиглагдаж байна.

- 18-35 насны залуучуудын улс төрийн оролцоо харьцангуй өндөр (статистик дундаж утга – 2.61) байна.

- Гурван залуу тутмын хоёр нь улс төрийн ямар нэг сонгуульд оролцож байсан, түүнчлэн 2016 оны УИХ-ын сонгуульд оролцохоор байна.

- Залуучуудын сонгуулийн оролцоонд ажил эрхлэлт мэдэгдэхүйц нөлөөлж байна.

- Залуучуудын нас, боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр сонгуулийн оролцоо харьцангуй нэмэгдэх зүй тогтол ажиглагдаж байна.

- Хөдөө орон нутгийн залуучуудын сонгуулийн оролцоо Улаанбаатар хотын залуучуудын сонгуулийн оролцооноос харьцангуй өндөр байхаар байна.

- Залуучуудын улс төрийн оролцоо сул байгаа нь улс төрийн үйл явцын ач холбогдлын талаарх тэдний ойлголт, төсөөлөл дутмаг, улс төрийн намууд, улс төрчид итгэл төрүүлэхгүй байгаатай холбоотой нь тодорхой харагдаж байна.

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Улс төрийн үйл явц, оролцооны ач холбогдолыг таниулах, ойлгуулах, мэдээллээр хангах үйл ажиллагаа зохион байгуулах нь залуучуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлэх практик арга зам болно.

- Залуучуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлэх сургалтын модуль боловсруулж, зорилтот бүлэгт чиглэсэн хэлбэрээр ашиглах бодит шаардлага урган гарч байна.

- Залуучуудын улс төрийн оролцоонд улс төр, эрх зүйн орчин нөлөөлж байгаа эсэхийг үнэлэх судалгаа хийж, залуучуудын улс төрийн оролцоонд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бүрэн судалж, үр дүнд нь тулгуурлан оролцоог нэмэгдүүлэх ажил зохион байгуулах хэрэгтэй байна.

- Цаашид залуучуудын сонгуулийн зан үйлийг тодорхойлох макро, микро түвшиний судалгаа хийх нь онолын болон практик ач холбогдолтой байх болно гэж үзэж байна. ■

⁷ William H. Flanagan and Nancy H. Zingale, Political Behavior of the American Electorate, 9th ed. (Washington, DC: CQ Press, 1999).